



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2022

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**ХУУЛЬ ЗҮЙН
СУДАЛГААНЫ ТӨВ**

Улаанбаатар хот

Удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur)
С.Сүхбаатар	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор (LL.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Түмэндэмбэрэл	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Т.Намуун	Эрдэм шинжилгээний ажилтан
З.Мөнгөлжин	Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

УДИРТГАЛ	5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгаан.....	6
1.2. Үнэлгээ хийх хүрээ	7
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	7
1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	13
1.5. Судалгааны арга	14
ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	14
2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	14
2.1.1. Төрийн тусгай хамгаалалтын талаарх ерөнхий ойлголт	14
2.1.2. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж.....	16
2.1.3. ТТХтХ-ийн зарим нэр томъёоны талаарх ойлголт	19
2.1.4. Албан хаагч, иргэн, арга хэмжээ, барилга, тээврийн хэрэгсэл	22
2.2. “Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	36
2.2.1. Төрийн тусгай хамгаалалтын байгууллага	36
2.2.2. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын эрх зүйн байдал	42
2.2.3. Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагчдын эрх зүйн байдал.....	45
Дүгнэлт, Зөвлөмж.....	69
Ном зүй	77

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ТТХтХ- Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

ТТХГ- Төрийн тусгай хамгаалалтын газар

ТБтХ- Тагнуулын байгууллагын тухай хууль

БНСУ- Бүгд найрамдах Солонгос улс

АНУ- Америкийн нэгдсэн улс

ОХУ- Оросын холбооны улс

ШШГтХ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

УДИРТГАЛ

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль нь төрийн тусгай хамгаалалт, түүний хамрах хүрээ, хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор анх 1995 онд батлагдсан. Үүнээс хойш нийт 9 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр баталсан нэмэлт өөрчлөлтөөр Төрийн тусгай хамгаалалтын газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан байна.¹

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт судалгаа хийж буй зорилго нь хууль батлагдсанаас хойшхи 26 жилийн хугацаанд нийгэм, эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлүүд явагдаж хуулийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл үүсч байгаа бөгөөд тус хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг эрэлхийлж, уг хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг дэвшүүлж, дүгнэлт зөвлөмж өгөх зорилготой болно. Иймд Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын газар /цаашид “ТТХГ” гэх/-ын захиалгаар “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

¹ Төрийн тусгай хамгаалалтын газрын цахим хуудас. <https://sspa.gov.mn/mn/page?id=1> 2022 оны 2-р сард хандав.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэх шаардлагатай. Төлөвлөх үе шатанд дараах асуудлыг тодруулна. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
4. Судалгааны арга хэлбэрийг сонгох

Төлөвлөх үе шатад асуудлуудын онцлогийг харгалзан зарим асуудлыг нэгтгэж, нэг дэд хэсэгт багтаан харьцуулалтын аргаар судалгааг гүйцэтгэв.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль нь төрийн тусгай хамгаалалт, түүний хамрах хүрээ, хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор анх 1995 онд батлагдсан. Үүнээс хойш нийт 9 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд Монгол улсын их хурлаас 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдөр баталсан нэмэлт өөрчлөлтөөр Төрийн тусгай хамгаалалтын газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан. Тиймээс тус газар нь хуулиар хүлээсэн чиг үүргээ зохих түвшинд гүйцэтгэхэд тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх шаардлага үүсч байна. Мөн хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан боловч тус хуульд сүүлийн 5 жилийн хугацаанд нэг ч удаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.² Төрийн тусгай хамгаалалтад хамаарах ихэнх эх сурвалж улсын нууцад хамаардаг ба төрийн тусгай хамгаалалттай холбоотой ном, судалгааны материал хомс байгаа тул уг судалгааг нийтэд ил болсон эх сурвалжийн хүрээнд хийсэн. Тиймээс тусгай хамгаалалтын газрын дотоод журам, үйл ажиллагаа, хамгаалалтын стандарт гэх мэт улсын нууцад хамаарах эх сурвалжийг ашиглаагүй болно.

Иймд төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх судалгааны хүрээг уг хуулийн нийт 17 зүйл заалт, төрийн тусгай хамгаалалтын газартай холбогдох Засгийн газрын тогтоол, шийдвэр, гадны орны хамгаалалтын тухай хууль бусад эх сурвалжийн хүрээнд гүйцэтгэхээр сонголоо.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтүүдээс дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонгож байна. Үүнд:

Аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

Аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал”. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.1.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

² Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн заасан байна.

ТТХтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалт, түүний хамрах хүрээ, хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан.

Түүнчлэн мөн хуулийн 2 дугаар зүйлд зааснаар “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан тул тус хуульд заасан үндсэн зарчим бусад хуулиудад зөрчигдөж буй эсэхийг тодорхойлохын тулд холбогдох хуулиудыг мөн шинжлэн судлах юм.

ТТХтХ-ийн дараах зүйл, заалтад үнэлгээ хийхээр сонголоо. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	2 дугаар зүйл	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
2	3 дугаар зүйл	Төрийн тусгай хамгаалалт нь аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн.
	5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 6 дахь заалт	5.1.6 "төрийн тусгай хамгаалалтын бүс" гэж гадуур хамгаалалт зохиож байгаа болон төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, нутаг дэвсгэрийг тус тус хэлнэ.

1.1.2. “Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалтын практикт хэрэгжиж буй байдал, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлоход чиглэгддэг. Иймд практикт гарч буй зарим асуудлыг тодруулах зорилгоор хуулийн дараах зүйл, заалтыг сонгож авав. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон заалт	Зүйл, Зүйл, заалтын агуулга
10	дугаар зүйлийн 2, 3 дахь заалт	10.2 Төрийн тусгай хамгаалалтын газар хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын болон дүн шинжилгээний нэгжтэй байх бөгөөд зохион байгуулалтын бүтцийг төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн Засгийн газар тогтооно; 10.3 Төрийн тусгай хамгаалалтын газар туг, бэлгэ тэмдэгтэй байна. Туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална.
11	дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5, 7 дахь заалт	11.2. Төрийн тусгай хамгаалалтын газар дараахь үүрэгтэй байна: 3/хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гадуур болон далд хамгаалалт зохион байгуулах; 5/төрийн тусгай хамгаалалтын бүс, барилга, бусад зүйлийг харуулын салбарын хамгаалалтад авах; 7/хамгаалуулагчийг зориулалтын автотээврийн хэрэгслээр үйлчлэх;
12	дугаар зүйлийн 1 дэх заалт	12.1.Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/төрийн тусгай хамгаалалтын газрын хүний нөөцийг бэлтгэх, зэвсэг, техникээр хангах, бэхжүүлэх талаарх

саналаа Засгийн газарт танилцуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2/төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

3/энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасан техникийн үзлэг, шалгалт хийх зөвшөөрөл олгох;

4/батлагдсан төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

5/хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу албан хаагчийг томилох, чөлөөлөх, цэргийн цол олгох, бууруулах, хураах, сэргээх, шагнаж урамшуулах, ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх;

6/төрийн тусгай хамгаалалтад оролцож байгаа бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;

7/байгууллагыг төлөөлөн дотоод, гадаадын байгууллагатай харилцан ажиллах.

**13 дугаар зүйлийн 1, 2,
4, 5 дахь заалт**

13.1 Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэнийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь төрийн тусгай албан хаагч мөн.

13.2 Төрийн тусгай хамгаалалтын албанд 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг ажиллуулна.

13.4 Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах,

15 дугаар зүйл

туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална.

13.5 Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газар батална.

15. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч албан үүрэг гүйцэтгэж байхдаа дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1/төрийн тусгай хамгаалалттай холбогдсон хүсэлт, шаардлагыг иргэд, албан тушаалтанд тавих, дэмжлэг туслалцаа авах, төрийн тусгай хамгаалалтын бүс, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх бичгийг шалгах, эд зүйлд үзлэг хийх, хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлээс сорьц авч шинжилгээ хийх, ашиглахыг хориглох, төрийн тусгай хамгаалалтын бүсэд ажиллах бусад байгууллагын ажилтанд зааварчилгаа өгөх, хяналт тавих;

2/төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд сэжиг бүхий этгээд илэрвэл түүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, уул этгээдийг 2 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис илэрвэл хураан авах, холбогдох байгууллагад шилжүүлэх;

3/хамгаалуулагчид бодитой аюул учирсан тохиолдолд шаардлагатай бол хуулиар хориглосноос бусад автотээврийн хэрэгсэл болон бусад уналга дайчлах;

4/төрийн тусгай хамгаалалтын ажлын шаардлагаар байгууллага, иргэдийн телефон утсаар үнэ төлбөргүй, нийтийн холбооны хэрэгслээр дараалал харгалзахгүй үйлчлүүлэх, байр, орон сууцанд эзэмшигчийн зөвшөөрлөөр нэвтрэн орох, үзлэг хийх;

5/албан үүргээ гүйцэтгэж байхдаа зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах, тогтоосон журмын дагуу хэрэглэх;

6/өргөсөн тангарагтаа үнэнч байх;

7/удирдах байгууллагын шийдвэр, захирах даргын тушаалыг биелүүлэх;

8/хамгаалуулагчийн хувийн нууцыг чанд хадгалах;

9/хамгаалалт, үйлчилгээний ажлын мэдлэг, тусгай бэлтгэлээ байнга дээшлүүлж, шударга, санаачилгатай ажиллах.

**16 дугаар зүйлийн 1, 8,
11 дэх заалт**

16.1 Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.

16.8 Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн амралт олгох ба төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

16.11 Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.

**17 дугаар зүйлийн 3
дахь заалт**

17.3 Шаардлагатай тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амралтын цагийг хязгаарлах буюу илүү цагаар ажиллуулж болно.

21 дүгээр зүйл

21. Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, алба хаагч төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараахь зэвсэг болон тусгай хэрэгсэл, мэх хэрэглэнэ:

1/галт зэвсэг;

2/хүйтэн зэвсэг;

3/нэг бүрийн тусгай хэрэгсэл;

4/олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл;

5/автотээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;

22 дугаар зүйлийн 5 дахь заалт

6/хамгаалах тусгай хэрэгсэл;
7/зэвсэггүйгээр тулалдах мэх;
8/албаны нохой.

22.5 Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь эмнэлгийн байгууллага, захирах даргадаа, захирах дарга нь прокурорт тус тус нэн даруй мэдэгдэнэ.

1.4.Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс 3.5.3.1. “байх ёстой болон одоо байгаа байдал”, мөн 3.5.3.4. “тохиолдол судлах” 3 хэлбэрийг сонголоо. Үүнд:

1. Байх ёстой болон одоо байгаа- энэхүү хууль нь практикт ямар асуудал үүсгэж буйг судлан тогтооно.
2. Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш- хууль тогтоомж хүчин төгөлдөр болсноос хойш төрийн тусгай хамгаалалттай холбогдолтой хэрэгт дүн шинжилгээ хийнэ.
3. Тохиолдол судлах- гадаад орны туршлага, онцлог, манай орноос ялгаатай байдал зэргийг харьцуулах замаар Монгол Улсын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийг зорьж байна. Өөрөөр хэлбэл, үнэлгээний хүрээгээр тогтоосон хуулийн заалтууд бусад улс орнуудын хувьд хэрхэн хэрэгждэг талаар судлах үүднээс “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг сонгосон болно.

Харин шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тохируулан асуулт дэвшүүлж, дараах асуултуудыг боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн зохицуулалт, хамрах хүрээ нь тус хуулийн зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хэрэглээний болон практикийн ямар асуудал үүсэж, тус зохицуулалт хэрхэн хэрэгжиж байна вэ?

1.5.Судалгааны арга

Тус судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” дээр тулгуурлан холбогдох хууль тогтоомжоос үр нөлөө бүхий 17 зүйл заалтыг хэсэгчлэн хувааж уг аргачлалын 3.4.1-д заасан “зорилгод хүрсэн түвшин” болон 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр тус тус дүгнэх болно. Ингэхдээ текст анализийн арга, гадны эх сурвалжийг ашиглан харьцуулсан судалгааны аргаар гүйцэтгэнэ.

ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн томъёоллын дагуу ТТХтХ-аас сонгож авсан зохицуулалтуудад дараах байдлаар үнэлгээ хийлээ.

2.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ТТХтХ-ийн үндсэн зорилтыг “төрийн тусгай хамгаалалт, түүний хамрах хүрээ, хамгаалалтыг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” хэмээн уг хуулийн 1 дүгээр зүйлд заажээ. Энэхүү зорилтыг тодотгохын тулд дараах агуулгын хүрээнд “зорилгод хүрсэн түвшин” шалгуураар үнэлгээ хийлээ.

2.1.1. Төрийн тусгай хамгаалалтын талаарх ерөнхий ойлголт

ТТХтХ-ийн 3-р зүйлд “Төрийн тусгай хамгаалалт нь төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл

ажиллагаа мөн” хэмээн тодорхойлон заасан байна. Өөрөөр хэлбэл, төрийн тусгай хамгаалалт нь төрийн албан тушаалтан, иргэн, гадны орны төр засгийн тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд хэмжээний зочин болон эдгээрт хамаарах байгууламжийг төрийн тусгай хамгаалалтад авч байна.

Монгол Улсын ТТХтХ-ийн онцлог нь төрийн тусгай хамгаалалтад байх хүн болон байгууламж хоёрыг хоёуланг нь зохицуулж байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл төрийн тусгай хамгаалалтад авахаар заасан субъект болон объектыг хамтад нь нэг хуулиар зохицуулахаар тусгасан нь тус хуулийн хамрах хүрээ нь өргөн байх нөхцлийг бүрдүүлж, улмаар хуулийн хэрэгжилт болон зорилгодоо хүрэхэд хүндрэл учруулж байж болзошгүйг онцлох нь зүйтэй юм. Мөн ТТХтХ-д “ордон, өргөө, зориулалтын орон сууц” гэдэгт юуг хамааруулж байгаа эсэх, хоорондоо юугаар ялгаатай эсэх нь тодорхойгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд асуудал үүсгэх, мөн холбогдох албан тушаалтнуудад албан үүргээ гүйцэлдүүлэхэд ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэх магадлалтай. Тиймээс, субъект болон объектын ангилалыг системчлэлтэйгээр хуульчлан зохицуулж, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлох шаардлага тулгарч байна.

Гадаад орны туршлагаас үзвэл төрийн тусгай хамгаалалтын объект буюу субъектыг 2 өөр хуулиар тус тусад нь зохицуулсан тохиолдол байна. Тухайлбал, БНСУ-ын хувьд төрийн тусгай хамгаалалтад авах субъектыг “Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хууль” -аар, харин объектыг “Аюулаас хамгаалах тухай нэгдсэн хууль”-аар тус тус ялгамжтай зохицуулдаг байна. БНСУ-ын “Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хууль (대통령 경호 등에 관한 법률)”-ийн 2.1-р зүйлд “Хамгаалалт гэдэг нь хамгаалуулагчийн амь нас, эд хөрөнгийг хамгаалахын тулд биед учирч болзошгүй аюулаас урьдчилан хамгаалж, тодорхой нутаг дэвсгэрийг хамгаалах, харуулд гарах гэх мэт урьдчилан хамгаалах аюулгүйн үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг бол “Аюулаас хамгаалах тухай нэгдсэн хууль (통합방위법)”-н 2.13-р зүйлд “Улсын чухал байгууламж гэдэг нь төрийн албаны байгууллага, нисэх онгоц болон усан онгоцны боомт, үйлдвэрлэлийн байгууламж зэрэг нь дайсанд эзлэгдэх, үйл ажиллагаа нь доголдох тохиолдолд улсын аюулгүй байдал, ард иргэдийн ахуй амьдралд сөрөг нөлөө үзүүлэх байгууламжийг хэлнэ” гэж заасан байдаг. Үүнээс үзвэл төрийн тусгай хамгаалалтыг үндсэн 2 төрлөөр ангилж, субъект болон

объектын хамгаалалт гэж хувааж үзсэн байна. Субъектын хамгаалалт нь хамгаалуулагчийн амьд явах баталгааг хангах зорилгоор учирч болзошгүй аюулаас урьдчилан хамгаалах үйл ажиллагааг ойлгож байгаа бол объектын хамгаалалт гэдэгт хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан хамгаалалтад авсан байгууламж болон улсын аюулгүй байдал, ард иргэдийн ахуйд нэн хэрэгцээтэй байгууламжийн хамгаалалтыг ойлгож байна. Иймд БНСУ-ын хувьд төрийн тусгай хамгаалалт гэдэг нь хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор “аюулгүйн үйл ажиллагаа явуулах үйл явц” хэмээн агуулгыг илэрхийлж, тусгасан байна.

Харин Монгол Улсын хувьд төрийн тусгай хамгаалалтыг хуульд тодорхойлохдоо “аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалалтад авахаар заасан албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл” гэх зэргээр нэг бүрчлэн заасан байгаа нь нэг талаасаа хамгаалалтын үйл ажиллагааг баригдмал, явцуу утгаар ойлгож, “иргэний амь бие, ордон, өргөө” гэх мэт ерөнхий, давхардмал утгатай үгсээр томъёолсон нь хамгаалалтын хуулийн хэрэгжилтэд хүндрэл учруулж болзошгүй байна. Иймд гадны орны жишгээс туршлага судлан, төрийн тусгай хамгаалалтыг тодорхойлон тусгахдаа “хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах бүх талын үйл ажиллагаа” гэх зэргээр ойлгох нь зохимжтой. Өөрөөр хэлбэл, төрийн тусгай хамгаалалтын гол зорилго нь хамгаалуулагчийн аюулгүй байдал хэмээн субьектив байдлаар ойлгож харин объектын хамгаалалтыг субьектын аюулгүй байдлыг хамгаалахын тулд хийж буй хамгаалалт гэсэн утгыг илэрхийлж, боловсронгуй тодорхойлох нь зүйтэй.

2.1.2. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж

Шалгуур үзүүлэлтийн томъёолол

ТТХтХ нь бусад хууль, болон тэдгээрийн бусад акттай нийцэж, бүрдэх зорилгодоо хүрч чадсан эсэх?

ТТХтХ-ийн 2-р зүйлд “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан. Иймд

тус хууль нь бусад ямар хуулиудаас бүрдэж байгааг тодруулж, тэдгээртэй нийцэж байгаа эсэхийг тодруулах шаардлагатай. Тус заалтад дүн шинжилгээ хийвээс ТТХТХ нь нэн тэргүүнд Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хуультай нийцсэн байх зорилгыг агуулж байна. Иймд Үндсэн хуультай нийцсэн байх ёстой шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүн шинжилгээ хийвэл, Үндсэн хуулийн 10-р зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн заасан байна. Иймд нэгдүгээрт ТТХТХ-д хамаарагдах нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцсэн байх шаардлага тулгарч, нэгдэн орсон конвенцийн стандарт хүрээ нь ТТХТХ тогтоомжид тусгалаа олсон эсэх, тэдгээртэй нийцсэн байх ерөнхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэлт өгөх нь чухал.

Нэгдүгээрт, Монгол улсын Төрийн тусгай хамгаалалтын газар нь 2014 оны 05 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүдэд Берлинд зохион байгуулагдсан “Олон улсын төрийн хамгаалалтын байгууллагуудын холбоо”-ны (APPS-Association of Personal Protection Services) 13 дахь удаагийн уулзалтад оролцож, гишүүнээр элсэн орсон байна³. Мөн Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1973 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталж, 1974 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болж, улмаар Монгол Улс 1974 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан байна. Тус олон улсын конвенцод нэгдэн орсон орнууд нь олон улсын энх тайвныг сахиулах, аюулгүй байдлыг хангах шаардлага тулгарсны үндсэнд дипломат төлөөлөгчид болон бусад олон улсын хамгаалалтад байдаг хүмүүсийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэхийн тулд зохих тууштай арга хэмжээ авах үүргийг тус конвенцоор хүлээсэн⁴. Иймд Монгол Улсын ТТХТХ-ийн утга агуулга, мөн тус нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц нь хоорондоо нийцэж буй эсэхэд үнэлэлт өгөх шаардлага тулгарч байна.

³ Төрийн тусгай хамгаалалтын газраас ирүүлсэн мэдээллээс.

⁴ Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц

Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенцоор “олон улсын хамгаалалтад байдаг хүн” гэсэн нэр томъёог тодорхойлон тусгасан бол ТТХтХ-д “олон улсын хамгаалалтад байгаа хүн” гэсэн нэр томъёо байхгүй буюу гагцхүү “өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин” гэсэн нэршлээр ойлгож хуульчлан зохицуулсан байгаа нь практикт ойлгомжгүй байдал үүсгэх, нэр томъёо, утга агуулгын зөрүү, давхардал гарах зэрэг сөрөг үр дагавар үүсгэж байна. Үүнээс улбаалан ТТХтХ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.1-т заасан хуулийн төслийн агуулгын нийтлэг шаардлага болох “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх” шаардлага, зарчмыг зөрчиж байна. Энэхүү үр дагавар нь цаашлаад тус хууль олон улсын гэрээ, конвенцоос бүрдэх, нийцэх зорилгыг үгүйсгэж, зорилгодоо хүрэхгүй байх нөхцлийг үүсгэж байна. Энэ тухай судалгааны дараа дараагийн бүлэгт илүү дэлгэрэнгүй тайлбарлах болно⁵.

Гадаад орны туршлагаас үзэхэд ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын тухай хуулийн 4-р зүйлд “Холбооны аюулгүй байдлын албаны үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь ОХУ-ын Үндсэн хууль, энэхүү Холбооны хууль, ОХУ-ын бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад актуудаас бүрдэнэ” хэмээн заасан байна⁶. Мөн хуулийн тус зүйл заалт дээр “Холбооны аюулгүй байдлын албаны үйл ажиллагаа нь ОХУ-ын олон улсын гэрээний дагуу явагдана” гэж тус тус заасан байна⁷. Иймд бусад улсын туршлагаас судлан Монгол улсын ТТХтХ-ийг мөн адил олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх шаардлага тулгарч буйг онцлох нь зүйтэй.

Хоёрдугаарт, ТТХтХ нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцэх зорилгын хүрээнд үнэлэлт өгөх шаардлагатай. Монгол Улсын Үндсэн хуулийн 10-р зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” мөн 4 дэх хэсэгт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин

⁵ Дэлгэрэнгүйг судалгааны 28-29-р хуудсаас үзнэ үү

⁶ ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын тухай хууль, 1995 он

⁷ ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын тухай хууль, 1995 он
Federal law on the federal security service

хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж тус тус заасан байдаг. Мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 21.2-т “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй” гэж заасан байна. Иймд ТТХтХ нь хүний эрхийг зөрчсөн байх ёсгүй, аль эсвэл хүний эрхийг хамгийн бага хэмжээгээр хязгаарласан байх ёстой гэсэн шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Мөн ТТХтХ-ийн зорилгын хүрээнд ТТХтХ нь бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэхгүй байгаа байдал ажиглагдаж байна. Тодруулбал, ТТХтХ-д холбогдох Засгийн газрын 50-р тогтоолын 4.1.1-т “тусгасан бие бялдар, гоозүйн шалгуур үзүүлэлт” нь Үндсэн хуулиар хамгаалсан хүний эрх, эрх чөлөөнд харшилсан зохицуулалт байгааг онцлох нь зүйн хэрэг. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн хязгаарлалтыг ТТХтХ-ийн холбогдох Засгийн газрын тогтоол, журмаар баталж байгаа нь бусад хуультай буюу Төрийн албаны тухай хуультай нийцсэн байх ёстой наад захын шалгуурыг зөрчиж, хуульд нийцэхгүй байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй. ТАтХ-ийн 23.1-т “Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно” гэж заасан заалтыг зөрчиж байна. Иймд ТТХтХ-ийн 10-р зүйлийн 5 дахь хэсэгт “Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлага...” гэсэн заалтад үндэслэн тус хууль нь Төрийн албаны тухай хууль /цаашид ТАтХ гэх/-тай нийцсэн байх зайлшгүй шаардлагыг хангахгүй байна. Иймээс, ТТХтХ-ын 2-р зүйлд заасан зохицуулалт зорилгодоо бүрэн хүрээгүй буюу Үндсэн хууль бусад хуульд заасан шаардлага хангаагүй, нийцээгүй байгааг онцолж байна. Тэрч утгаараа цаашид ТТХтХ нь бусад хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, нийцүүлэх шаардлага тулгарч байна.

2.1.3. ТТХтХ-ийн зарим нэр томъёоны талаарх ойлголт

Шалгуур үзүүлэлтийн томъёолол

Төрийн тусгай хамгаалалт нь төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага,

албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа болж чадсан байх зорилгодоо хүрч чадсан эсэх?

ТТХТХ-д нийт зургаан төрлийн нэр томъёог тодорхойлсон байдаг бөгөөд уг хуулийн 5.1.6-д заасан “Тусгай хамгаалалтын бүс” гэсэн нэр томъёог сонгон авч судаллаа.

“Тусгай хамгаалалтын бүс”

ТТХТХ-ийн 5-р зүйлийн 6 дахь хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын бүс гэж гадуур хамгаалалт зохиож байгаа болон төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, нутаг дэвсгэрийг тус тус хэлнэ.” гэж заасан байдаг. Гэвч ямар хууль ёсны шалгуур үзүүлэлтүүдээр төрийн тусгай хамгаалалтын бүсийг тодорхойлж байгаа эсэх, хамгаалалтын бүсийн хил хязгаарыг хэрхэн тогтоож байгаа эсэх нь тодорхойгүй буюу зохицуулалтгүй байна. Тиймээс “Төрийн тусгай хамгаалалтын бүс” гэдэг ойлголтыг илүү нарийвчлан тодорхойлж, шалгуур үзүүлэлтийг тусгахын тулд БНСУ-ын тусгай хамгаалалтын бүсийн тухай илүү дэлгэрэнгүй судлах нь зүйтэй.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хуульд тусгай хамгаалалтын бүсийг хэрхэн ойлгодог, ямар зарчмаар бүсийг тодорхойлдог талаар тусгасан байдаг. Тус хуулийн 2.1-т “Тусгай хамгаалалтын бүс гэдэг нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагч болон бусад холбогдох байгууллагуудын алба хаагч нар хамгаалалтын үйл ажиллагаа явуулж буй бүсийг хэлнэ” гэж заасан байна. Үүнээс харьцуулан үзэхэд “Төрийн тусгай хамгаалалтын бүс” гэдэг нь Монгол Улсын хувьд төрийн тусгай хамгаалалт явагдаж байгаа газар, объектыг ойлгож байгаа бол БНСУ-ын хувьд төрийн тусгай алба хаагч, холбогдох байгууллагын алба хаагчийн тусгай хамгаалалт хийж буй орон зайг тусгай хамгаалалтын бүс гэж ялгамжтай ойлгож байна⁸. Ийнхүү зааж өгснөөр тодорхой нэгэн газар, объектод хязгаарлагдахгүй, баригдмал бус чөлөөтэй байдлаар хамгаалалтын ажиллагааг хийх боломжтой болох нөхцлийг бүрдүүлж байна.

Иймд бусад улсын туршлагаас үзэхэд хамгаалалтын зорилго, хэлбэрээсээ хамааран тодорхой хэмжээгээр хамгаалалтын бүсийг зохих хэлбэрээр оновчтой

⁸ БНСУ-ын Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хууль

тогтоох нь зүйтэй. Учир нь “хамгаалалтын бүс”-ийг тогтоох явцад Үндсэн хуульд заасан “Халдашгүй, чөлөөтэй байх”, “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” зэрэг иргэдийн эрхийг тодорхой байдлаар хязгаарлах болдог тул их нухацтай авч үзэх шаардлага тулгарч байна. Үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд эдгээр эрхийг зөвхөн хуулиар хязгаарлаж болох талаар Үндсэн хуульд тусгасан байдаг. Тиймээс “төрийн тусгай хамгаалалтын бүс”-ийг хэрхэн тогтоох вэ гэдэг асуудлыг чухалчлан авч үзэх нь зүй ёсны шаардлага юм.

БНСУ-д тусгай хамгаалалтын бүсийг тогтоохдоо “Зохистой байдлыг хадгалах зарчим-과잉금지원칙”-ыг баримталдаг. Төрийн тусгай хамгаалалтын бүсийг тогтоохдоо тогтоож болох хамгийн бага хязгаар хүрээгээр тогтоох бөгөөд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч болон холбогдох байгууллагын албан хаагч нь хамгаалалтын зорилгын хүрээнд зайлшгүй шаардлагатай тохиолдол үүсвэл хамгаалалтын бүсд замын хөдөлгөөний хязгаарлалт тогтоох, үзлэг хийх, нийтийн эмх замбараатай байдал тогтоох арга хэмжээ авч болно хэмээн хуульчлан заасан байна. Өөрөөр хэлбэл, хамгаалалтад авах бүс их байх тусам хүний эрхийн зөрчил их гарах тул байж болох хамгийн бага хэмжээгээр тогтоодог байна. Үүний дагуу төрийн тусгай хамгаалалт тогтоох хэрэгцээг тодорхойлж түүнд таарсан хамгалалтын аргыг сонгоно. Энэ нь хамгаалалтын зорилгыг хангахын тулд хэрэгжүүлэх хамгаалалтын аргуудаас иргэний эрхийг хамгийн багаар хөндөх арга хэрэгслийг сонгох байдлаар хэрэгжүүлдэг.

Үүнтэй холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бүсийг “Иргэний нийтлэг эрхийн хамгаалалт”-ыг чухалчлах уу эсвэл “Төрийн тусгай алба хаагчийн үзэл бодол”-ыг чухалчилж тогтоох уу гэдэг асуудал гардаг. Сүүлийн үед ардчилсан дэглэмтэй орнуудад төрийн тусгай хамгаалалтын бүсийг тогтоохдоо “Иргэний нийтлэг эрхийн хамгаалалт”-ыг чухалчилж иргэдийн эрхийг хөндөхгүй байхыг эрмэлздэг болсон бөгөөд зайлшгүй тохиолдолд эрхийн зөрчлийг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэхээр зохистой байдлыг хадгалах зарчмын дагуу тогтоож байна.

Тиймээс гадаад орны туршлагаас үзэхэд Монгол Улс нь төрийн тусгай хамгаалалтын бүсийг тогтоохдоо “Зохистой байдлыг хадгалах зарчим”-ын хүрээнд иргэдийн эрхийг хамгаалах үүднээс “хамгаалалтын бүс”-ийг байж болох

хамгийн бага хэмжээгээр тогтоож, хамгаалалтын арга хэрэгслээс хамгийн уян хатан хэрэгслийг сонгон хэрэгжүүлэх нь оновчтой байна. Өөрөөр хэлбэл “Төрийн тусгай алба хаагчийн үзэл бодол”, Засгийн газрын дурын шийдвэрийг харгалзан хамгаалалтын бүсийг тогтоох бус хүний эрхийг хүндэтгэх зарчмын хүрээнд “Иргэний нийтлэг эрхийн хамгаалалт”-ыг чухалчилсан хууль ёсны стандарт тогтоох хэрэгцээ шаардлага тулгамдаж байна.

2.1.4. Албан хаагч, иргэн, арга хэмжээ, барилга, тээврийн хэрэгсэл

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4

ТТХтХ-ийн хамрах хүрээ болох хуулиар тогтоосон субъект, албан тушаалтан, иргэн олон улсын арга хэмжээ, барилгын зохицуулалт хэрхэн хэрэгжиж байна вэ?

А. Албан тушаалтан

ТТХтХ-ийн 6 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн” -г хуульчлан зохицуулсан байна. Иймд тус заалтын хүрээнд тодорхойлон заасан **“албан тушаалтан”** болон **“өөрийн хамгаалалттай ирсэн өндөр, дээд хэмжээний зочин”** гэсэн нэр томъёог тодруулан судлах нь зүйтэй.

ТТХтХ-аар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, хоёрдугаарт, Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг орлон гүйцэтгэгч, гуравдугаарт, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан иргэнийг хуульд заасан хугацаанд, дөрөвдүгээрт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг сонгуулийн компани эхэлсэн өдрөөс сонгуулийн албан ёсны дүн гарах хүртэлх хугацаанд, Улсын Их Хурлын даргад болон Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигчийг нэр дэвшсэн өдрөөс албан ёсны шийдвэр гарах хүртэлх хугацаанд, тавдугаарт, Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин нь тус тус улсын тусгай хамгаалалтад байхаар заасан.

<p>ТТХТХ-ийн 6 дугаар зүйлд заасан “Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн” гэсэнд тус зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт дээр “Монгол улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин”</p>	<p>ТТХТХ-ийн 9-р зүйлийн 2.1 дэх хэсэгт “нэгдүгээр зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Монгол улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд хэмжээний зочин”</p>
---	---

Үүнээс нэгдүгээрт, дээрх зүйл заалтад заасан “өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин”-ны талаар судалж үзэхэд “Өөрийн хамгаалалттай ирсэн зочид”-ыг ямар шалгуураар сонгож ойлгож байгаа талаарх ялгаа заагийг практикт тодорхой болгоогүйгээс хууль хэрэглээний явцад “өөрийн хамгаалалттай ирсэн гадны бүх зочид, төлөөлөгч” бүр Монгол Улсын төрийн тусгай хамгаалалт авахаар ойлгогдож, гадаадын хамааралгүй албан тушаалтнуудыг төрийн тусгай хамгаалалтад авч буй байдал ажиглагдаж, ТТХГ нь үндэсний язгуур эрх ашигт ач холбогдолгүй хамгаалалтыг гүйцэтгэх тохиолдол олонтаа гарч байна. Тухайлбал, Арабын нэгдсэн улсын хөл бөмбөгийн холбооны тэргүүн Монгол Улсад айлчлахдаа өөрийн хамгаалалттай ирсэн гэх шалтгаанаар тус айлчлалын хугацаанд манай улс төрийн тусгай хамгаалалтад авсан байна. Учир нь төрийн өндөр албан тушаал хашдаггүй гадны субъектыг “өөрийн хамгаалалттай ирсэн” гэх үндэслэлээр хамгаалалтад авах нөхцөл байдал үүсч, улмаар төрийн тусгай хамгаалалтын газраас хүн хүч дутагдах, улсын төсөвт дарамт учруулах, бүрэн гүйцэт байх зарчим алдагдах зэрэг асуудал тулгарч, практикт сөрөг үр дагавар үүсгэж буй бөгөөд энэ нь хуулийн хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Гадны орны туршлагаас үзвэл БНСУ-ын Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хуулийн 4.5-д “Солонгос улсад айлчилж байгаа гадаад улсын төрийн өндөр албан тушаалтан болон түүний гэр бүлийг төрийн тусгай хамгаалалтад авна” гэж заасан бөгөөд төрийн тусгай хамгаалалтад авах субъектийг товч бөгөөд

тодорхой байдлаар тусгасан байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 3 дугаар зүйлд:⁹

- А. Ерөнхийлөгч түүний гэр бүл
- Б. Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн ба түүний гэр бүл
- В. Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд түүний гэр бүл, хүүхдийг тогтоосон хугацаанд
- Г. Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, түүний эхнэр, нөхөр
- Д. Гадаад орны төрийн тэргүүн эсвэл Засгийн газрын тэргүүн, түүний гэр бүлийн гишүүн Солонгос улсад айлчилж байгаа бол
- Е. Хамгаалалтын албаны дарга хамгаалалт шаардлагатай гэж үзсэн гадаад, дотоод албан тушаалтан гэх зэргээр хуульчлан тогтоосон байна.

Харин АНУ-ын 18-р хуулийн 203-р бүлэг, 3056-р хэсэгт хамгаалалтад авах субъектүүдыг тухайлан нэрлэж заасан бөгөөд үүнд:

- А. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч;
- Б. Тэдгээрийн гэр бүлийн гишүүд;
- В. Ерөнхийлөгч асан болон тэдгээрийн эхнэр/нөхрийг насан туршид нь;
- Г. Өмнөх Ерөнхийлөгчдийн 16 нас хүрээгүй хүүхдүүд; Гадаадын улс орнуудаас айлчилж буй төрийн болон засгийн газрын тэргүүнүүд;
- Д. АНУ-д айлчилж буй гадаад улс орны эрхэм дээд зочид болон Ерөнхийлөгч үүрэг болгосон тохиолдолд гадаад улс оронд тусгай үүрэг, даалгавар гүйцэтгэж буй албаны төлөөлөгчид¹⁰ гэх зэргээр хамгаалалтад авах хамгаалалтал субъектыг хуульчлан тусгасан байна.

⁹ Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны тухай хуулийн 3 дугаар зүйл

¹⁰ 18 U.S. Code §30563056 - Powers, authorities, and duties of United States Secret Service

<https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>

Гадны орны төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, гадны зочныг хүснэгтээр харьцуулан нарийвчлан харуулвал:

АНУ	БНСУ	Монгол улс
<p>- Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч (эсвэл Ерөнхийлөгчийн Тамгын газрыг залгамжлах дарааллаар бусад хүмүүс),</p> <p>- Сонгогдсон ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч түүний гэр бүл</p> <p>- Эхнэр, нөхөр нь дахин гэрлэхээс бусад тохиолдолд өмнөх ерөнхийлөгчид, тэдний эхнэр, нөхөр 16 нас хүртлээ өмнөх ерөнхийлөгчийн хүүхдүүд</p> <p>- Айлчилж буй гадаад улс, засгийн газрын тэргүүнүүд, тэдэнтэй хамт зорчиж буй эхнэр, нөхөр,</p> <p>- АНУ-д зорчиж буй гадаадын бусад хүндэт зочид, гадаадад тусгай үүрэг гүйцэтгэж буй АНУ-ын албан ёсны төлөөлөгчид</p> <p>- Ерөнхийлөгчийн сонгууль болохоос хойш 120 хоногийн дотор Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчид томоохон нэр дэвшигчид, тэдний эхнэр, нөхөр</p> <p>- Үндэсний аюулгүй байдлын албаны нарийн бичгийн даргын томилсон Үндэсний аюулгүй байдлын тусгай арга хэмжээ</p> <p>- Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу тодорхойлогдсон бусад хүмүүс</p>	<p>-Ерөнхийлөгч, түүний гэр бүл</p> <p>-Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан хүн, түүний гэр бүл</p> <p>-Ерөнхийлөгчийн алба хашиж байса хүн, эүүний гэр бүл</p> <p>-Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, түүний гэр бүл</p> <p>-Гадны орны төрийн тэргүүн, ерөнхий сайд, түүний гэр бүл</p> <p>-Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны даргын шийдвэрээр хамгаалалт нэн шаардлагатай гэж үзсэн хүн</p>	<p>-Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд;</p> <p>-Улсын Их Хурлын даргын үүрэг гүйцэтгэгч, Ерөнхий сайдын үүргийг орлон гүйцэтгэгч;</p> <p>-Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан иргэнийг хуульд заасан хугацаанд;</p> <p>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг сонгуулийн компани эхэлсэн өдрөөс сонгуулийн албан ёсны дүн гарах хүртэлх хугацаанд, Улсын Их Хурлын даргад болон Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигчийг нэр дэвшсэн өдрөөс албан ёсны шийдвэр гарах хүртэлх хугацаанд;</p> <p>-Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн дээд, өндөр хэмжээний зочин.</p>

Иймд өргөн хүрээг хамарсан зохицуулалтын улмаас хууль хэрэглэх явцад ойлгомжгүй байдал үүсгэх, сөрөг үр дагавар үүсгэх магадлалтай тул төрийн тусгай хамгаалалтад байх “гадны өндөр, дээд хэмжээний зочин” гэх хүрээг илүү боловсронгуй болгох үүднээс бусад хуулийн тайлбарт хэрхэн ойлгож, тайлбарлаж буйг харах нь зүйтэй. Монгол Улсын 2002 оны эрүүгийн хуулийн тайлбарт “гадны өндөр, дээд хэмжээний зочин” гэсэн ойлголтыг “гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтнууд, дипломат элч, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл буюу Монгол Улсад өөрийн улсын төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд хамаах бөгөөд дээр дурдсан хүмүүсийн орон байр, албан өрөө, тээврийн хэрэгсэл олон улсын хамгаалалтад байна.” хэмээн тодорхойлсон байна¹¹.

Мөн “Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц”-ийн 1-р зүйлд “Олон улсын хамгаалалтад байх хүн”-ийг нэгдүгээрт, төрийн тэргүүн, ялангуяа тухайн улсын Үндсэн хуулийн дагуу төрийн тэргүүний чиг үүргийг гүйцэтгэж буй хамтын удирдлагын байгууллагын аливаа гишүүн, Засгийн газрын тэргүүн болон гадаад хэргийн сайд, түүнчлэн тэднийг дагалдан яваа гэр бүлийн гишүүд, хоёрдугаарт, гэмт хэрэг гарсан газарт олон улсын эрх зүйн дагуу өөрийгөө, өөрийн эрх чөлөө болон нэр төрөө аливаа халдлагаас тусгайлан хамгаалуулах эрхтэй аливаа улсын төлөөлөгч буюу албан тушаалтан, олон улсын Засгийн газар хоорондын байгууллагын албан тушаалтан буюу өөр төлөөлөгч, түүний албан байр, орон сууц, тээврийн хэрэгслийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн үед, түүнчлэн тэдэнтэй хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг ойлгоно гэж заасан байдаг.

Тиймээс ТТХТХ-ын 6.5-р зүйлд заасан “өөрийн хамгаалалттай ирсэн зочин” гэх нэр томъёог өөрчлөн тухайн оронд төрийн тусгай хамгаалалтад байдаг “төрийн өндөр алба хашиж буй гадны зочин”, “Олон улсын хамгаалалтад байдаг хүн”-гэх зэргээр төрийн тусгай хамгаалалтын хүрээг хязгаарлах нь төрийн тусгай хамгаалалтын аюулгүй, тогтвортой, иж бүрэн байх боломжийг бүрдүүлэхээс

¹¹ Эрүүгийн хуулийн 301-р зүйл, 2002 он

гадна төрийн тусгай хамгаалалтад байгаа хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах, хүн хүчний зохицуулалт, төсвийн зардлыг зохистой хэрэглэх боломж бүрдэх юм.

Б. Иргэн

ТТХТХ-д “иргэн” гэх субъектыг төрийн тусгай хамгаалалтад авах, үүнтэй холбогдуулан тодорхой үүрэг хүлээлгэхээр дараах байдлаар хуульчилсан байна.

Холбогдох хуулийн заалт

1. 3 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалт нь аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хуулиар төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, **иргэний** амь бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа мөн.”
2. 5 дугаар зүйлд “хамгаалуулагч” гэж Монгол Улсын хууль, олон улсын гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон албан тушаалтан, **иргэнийг**”
3. 6 дугаар зүйлийн 1.3-д “Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан **иргэнийг** хуульд заасан хугацаанд”
4. 6 дугаар зүйлийн 6.3-д “Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад албан тушаалтан, **иргэнийг** төрийн тусгай хамгаалалтад хамааруулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.”
5. 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, **иргэн** нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг хүндэтгэн биелүүлнэ.”
6. 6 дугаар зүйлийн 6.5-д “Төрийн тусгай хамгаалалтад байгаа **иргэн**, албан тушаалтан гэмт хэрэгт холбогдон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, эсхүл яллагдагчаар цаашид хорьж, мөрдөх зайлшгүй шаардлагатай гэж үзэн шүүгчийн захирамж гарсан тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ үргэлжлэх хугацаанд түүний цалин, тэтгэмжээс бусад хангамж, үйлчилгээ, төрийн тусгай хамгаалалт түдгэлзэнэ.”
7. 6 дугаар зүйлийн 6.6-д “Төрийн тусгай хамгаалалтад байгаа **иргэн**, албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол хорих болон баривчлах ял эдлэх хугацаанд түүний цалин, тэтгэмжээс бусад хангамж, үйлчилгээ, төрийн тусгай хамгаалалт түдгэлзэнэ.”
8. 8 дугаар зүйлийн 9.2.3-д “гуравдугаар зэрэглэлийн төрийн тусгай хамгаалалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын алба хашиж байсан **иргэн** болон Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигч, Монгол Улсын хууль, олон

улсын гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтад авах бусад албан тушаалтан, **иргэн**"

Уг хуулийг агуулгын хүрээнд харахад нэгдүгээрт, олон улсын гэрээний дагуу төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоосон хүн, хоёрдугаарт, "төрийн өндөр алба" хашиж байсан хүнийг "иргэн" гэж ойлгож болохоор харагдаж байгаа ч энэ нь хууль хэрэглээний явцад төөрөгдөл үүсгэж болохоор байна. Нөгөө талаасаа "иргэн" гэх ерөнхий нэршлийг хэрэглэснээр төрийн тусгай хамгаалалтад байх субъектын хязгаарыг хэт өргөнөөр тогтоох боломжийг бий болгох эрсдэлтэй.

Төрийн тусгай хамгаалалт өндөр хөгжсөн гадны орон болох АНУ-ын жишээнээс авч үзвэл АНУ нь "protectee" буюу хамгаалагдах эрх бүхий субъектыг "Ерөнхийлөгч" ба "Нууц албаны хамгаалалтад байгаа бусад хүн" хэмээн үндсэн 2 ангиллаар ангилдаг байна. "Нууц албаны хамгаалалтад байгаа бусад хүн" гэдэг нь хуулийн дагуу хамгаалагдах эрх бүхий аливаа хүнийг хэлнэ¹² гэж заасан байх бөгөөд АНУ-ын 18-р хуулийн дагуу §3056-р зүйлд заасны дагуу "тодорхойлогдсон хамгаалагдах эрхтэй аливаа хүнийг хэлнэ" хэмээн нарийвчлан зохицуулсан байна. Иймд бусад гадны хууль тогтоомжийн хувьд ТТХтХ-д заасанчлан "иргэн" гэсэн өргөн агуулга бүхий зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн "нэг бүрчлэн заасан хамгаалагдах эрх бүхий субъектыг хамгаална" гэж тусган зохицуулсан байна.

Харин Монгол Улсын ТТХтХ-д тус агуулгыг багтааснаар хуулийн хэрэгжилтэд сөрөг үр дагавар үүсэж байна. Тухайлбал, төрийн тусгай хамгаалалтын объект болох Монгол Улсын Төрийн ордонд 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр "1000 багшийн дурсамж" уулзалт, зөвлөгөөнд оролцож байсан 87 настай хүн нас барсан хэрэг гарсан. Энэхүү асуудлаар төрийн тусгай хамгаалалттай барилга буюу төрийн ордон дотор байгаа бүх "иргэн" төрийн тусгай хамгаалалт авах эрх бүхий субъект мөн үү гэдэг асуудал хурцадмал байдлаар тавигдаж буй. Өөрөөр хэлбэл, төрийн тусгай хамгаалалтынхны түргэн тусламжийг авч чадалгүй хүний амь эрсэдсэнд хэн хариуцлага хүлээх вэ гэдэг

¹² 18 U.S. Code §3056

асуудал нийгэмд хөндөгдөж байгаа тул үүнийг хууль эрх зүйн хувьд нарийвчлан зохицуулах шаардлага тулгамдаж байна.

Эцэст нь МУ-ын аюулгүй байдлын үүднээс төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэнийг төрийн тусгай хамгаалалтад хамааруулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэхээр уг хуулийн 6 дугаар зүйлийн 3-д заасан байна. Тус зохицуулалтаар төрийн тусгай хамгаалалтад юуг авах эсэх нь Засгийн газрын бүрэн эрх байхаар хуульчлан заасан байх бөгөөд Монгол улсын аюулгүй байдлын эрх ашиг гэдэгт юуг ойлгож байгааг нарийвчлан судлах шаардлагатай байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1-т “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” гэж мөн 1.1.2-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана” гэж заасан байдаг. Үүнээс үзэхэд Улсын аюулгүй байдлын эрх ашиг гэсэн ойлголт өргөн утгатай тул тус зарчмыг баримтлан аливаа субъектыг хамгаалалтад авах нь тус заалтын бодит хэрэгжилтэд саад учруулж байна. Өөрөөр хэлбэл, ямар шалгуураар бусад албан тушаалтан, иргэнийг төрийн тусгай хамгаалалтад авахыг тодорхой зааж өгөх нь зүйтэй бөгөөд төрийн тусгай хамгаалалтад авах аливаа субъектыг хэн нэгний үзэмжээр бус харин Засгийн газрын тогтоол журмаар стандартчлан зааж, нарийвчлан зохицуулах нь оновчтой. Мөн уг үндэслэлээр бусад албан тушаалтан, иргэнийг төрийн тусгай хамгаалалтад авч байгаа тохиолдолд ямар хугацаанд хамгаалалтад байлгахыг зааж өгөх шаардлагатай байна.

Гадаад улсын хууль тогтоомжийн жишгээс үзэхэд төрийн тусгай хамгаалалтад хамааруулах асуудлыг Засгийн газар батлан, шийдвэрлэдэг тохиолдол тун ховор байна. Тухайлбал, АНУ-ын холбогдох хууль тогтоомжоос үзвэл аливаа объектыг төрийн тусгай хамгаалалтад авах жагсаалтыг зөвхөн хуулиараа тусгайлан заасан бөгөөд аливаа эрх бүхий этгээд буюу Ерөнхийлөгч нь төрийн тусгай хамгаалалтын жагсаалтыг дангаараа гаргах бүрэн эрхийг олгоогүй байна. Хэрэв шаардлагатай тохиолдолд гаргасан бол ямар стандартаар, яагаад хамгаалалтад авах болсон тухай дэлгэрэнгүй тайланг

бэлтгэж Конгресст танилцуулдаг хариуцлагын механизмтай байгааг онцлох нь зүйтэй. Энэ нь хэн нэгэн өөрийн үзэмжээр төрийн тусгай үйлчилгээг авах аль эсвэл олгох эрсдэлийг бууруулах эрх зүйн нөхцлийг бий болгосон байх ба төрийн тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах эрх бүхий субъектыг хуулиараа хязгаарласан онцлог зохицуулалт агуулж байна. Иймд ТТХТХ-ын агуулагдаж буй “иргэн” гэх нэршил бүхий субъект нь тус хуулийг хэрэгжүүлэх явцад ойлгомжгүй байдал бий болгох, сөрөг үр дагавар үүсгэж буй тул тус зохицуулалтыг улам нарийвчлах, тодорхой болгох, ойлголтын зөрүүг арилгах шаардлага тулгамдаж буйг онцлох нь зүйтэй.

В. Арга хэмжээ

ТТХТХ-ын 2-р бүлгийн 7-р зүйлд “Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн төрийн тусгай хамгаалалтад байна” хэмээн хуульчлан заасан байна.

Энэхүү заалтын хэрэгжилтийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан Төрийн ордонд зохион байгуулагдах тухай бүрт нь төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.¹³ Тухайлбал, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөний хувьд 2003-2019 онд 10 удаагийн олон улсын хурлын арга хэмжээнүүдийг төрийн тусгай хамгаалалтад авч, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. Тодруулбал, 2015 оны 09-р сарын 15-наас 18-ны өдрүүдэд “ЕБХАБ-ын Парламентын Ассемблейн 2015 оны намрын хурал”, 2016 оны 04 сарын 22-ноос 04 сарын 29-ний өдрүүдэд “АСЕП-ийн 9-р уулзалтын арга хэмжээ” мөн Улаанбаатар хотноо болсон Ази, Европын Парламентын түншлэлийн есдүгээр уулзалт, АСЕМ-ын Сангийн сайд нарын 12 дугаар уулзалт, Ази, Европийн түмний 11 дэх чуулга уулзалт, Ази, Европийн бизнесийн 15 дахь чуулга уулзалтуудыг төрийн тусгай хамгаалалтад авч зохих байдлаар аюулгүй

¹³ "Fact Sheet: National Special Security Events". Office of the Press Secretary, United States Department of Homeland Security. 2006-12-29. Archived from the original on 2011-07-12. Retrieved 2008-02-01

байдлыг хангаж ажилласан байх тул тус заалтын хэрэгжилтийн түвшин хангалттай гэж үзэхээр байна.¹⁴

Гэвч тус зохицуулалтад ямар хуралдаан, уулзалт, зөвлөгөөнийг олон улсын дээд хэмжээний буюу төрийн тусгай хамгаалалтын арга хэмжээ гэж ангилан авч үзэхийг тодорхойлон заагаагүйгээс хуулийн хэрэгжилтэд ойлгомжгүй үр дагаврыг үүсгэж байна. Тухайлбал, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн зэрэг хоорондоо юугаараа онцлог ялгаатай болох, ямар шалгуур үзүүлэлтээр тус арга хэмжээнүүдийг төрийн тусгай хамгаалалтад авах тухай тодорхой хуульчлан зохицуулсан зүйл заалт байхгүйгээс хэн нэгэн албан тушаалтны хийсвэр үзэмжээр төрийн тусгай хамгаалалтад авах нөхцөл үүсэж байна. Жишээлбэл, 2016 оны 07 сарын .22-ноос 29-ний өдрүүдэд “Цэргийн тагнуулын олон улсын арга хэмжээ” “Гамшгийн эрсдлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал” гэх зэрэг олон удаагийн арга хэмжээг ямар шалгуур үзүүлэлтээр сонгон авч, тусгай хамгаалалтад авах эрх үүсэж буй нь тодорхойгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөрөг үр дагавар үүсгэж байна.

АНУ-ын жишгээс үзэхэд АНУ-ын Нууц Алба нь Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн даргын удирдлаган дор Ерөнхийлөгчийн тогтоосон үндэсний ач холбогдол бүхий онцгой арга хэмжээний аюулгүй байдлын ажиллагааг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй хэмээн хуульчлан заасан байна.¹⁵ Үндэсний аюулгүй байдлын тусгай арга хэмжээ (A National Special Security Event (NSSE) нь АНУ-ын Дотоодын Аюулгүй байдлын газраас (DHS) терроризм болон бусад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзсэн үндэсний болон олон улсын ач холбогдолтой арга хэмжээг хэлэх юм. Эдгээр арга хэмжээнд дэлхийн удирдагчдын дээд хэмжээний уулзалт, олон улсын байгууллагуудын уулзалт, ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх хурал, ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол зэрэг үйл ажиллагаанууд хамаарна. Эдгээр үйл ажиллагаанд холбооны агентлагуудаас тухайн арга хэмжээнд оролцож байгаа хүмүүс болон тухайн арга хэмжээ болж буй нийгэмлэгийн аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангахын тулд хамтын ажиллагаа, дэмжлэг үзүүлэхийг шаарддаг. Тодруулбал, дараах

¹⁴ Төрийн тусгай хамгаалалтын газрын мэдээлэл.

¹⁵ АНУ-ын 18 дугаартай хуулийн 3056 дугаар бүлэг /АНУ-ын Төрийн хамгаалалтын албаны эрх мэдэл, бүрэн эрх, эрх ба үүрэг хариуцаараг/ <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>.

шалгууруудыг харгалзан Үндэсний аюулгүй байдлын тусгай арга хэмжээ (A National Special Security Event (NSSE) мөн эсэхийг нарийвчлан тооцдог байна.

- Өндөр албан тушаалтнуудын ирц: АНУ-ын засгийн газрын албан тушаалтнууд эсвэл гадаадын нэр хүндтэй хүмүүсийн оролцсон арга хэмжээ нь тухайн үйл явдлыг ямар ч осолгүй өнгөрөөх, осол гарсан тохиолдолд хангалттай нөөцийг бүрдүүлэхийн тулд холбооны бие даасан ашиг сонирхлыг бий болгох шаардлагатай.
- Үйл явдлын хэмжээ. Олон тооны оролцогчид оролцох тусам аюулгүй байдлын шаардлагыг нэмэгдүүлдэг. Нэмж дурдахад томоохон үйл явдлууд террористууд болон бусад гэмт хэрэгтнүүдийн, ялангуяа үй олноор хөнөөх зэвсэг ашиглах сонирхолтой хүмүүсийн анхаарлыг татах магадлал өндөр байдаг.
- Үйл явдлын ач холбогдол. Зарим үйл явдал нь түүхэн, улс төр, соёлын болон бусад бэлгэдлийн ач холбогдолтой бөгөөд террорист үйлдэл эсвэл бусад гэмт хэргийн талаар санаа зовоож болзошгүй.
- Үйл явдлын үргэлжлэх хугацаа. Мужийн болон орон нутгийн хууль сахиулах болон олон нийтийн аюулгүй байдлын агентлагууд өөрсдийн харьяаллын хүрээний томоохон арга хэмжээг (Дэлхийн цуврал, NASCAR уралдаан, Super Bowl, телевизийн шагнал гардуулах шоу гэх мэт) хангалттай аюулгүй байдлыг хангах хүн хүч шаардлагатай тохиолдолд
- Улсын болон орон нутгийн нөөц боллоцоо. Мужийн болон орон нутгийн харьяалалд үндэсний болон олон улсын ач холбогдолтой эдгээр томоохон үйл явдлыг иж бүрэн хамгаалахад шаардлагатай мэдлэг, туршлага, хүн хүч болон бусад хөрөнгө шаардлагатай тохиолдолд.
- Харьяаллын олон талт байдал. Олон улсын хууль сахиулах болон олон нийтийн аюулгүй байдлын байгууллагуудын хэмжээний арга хэмжээ.
- Аюулгүй байдлын үнэлгээ. Терроризм, бусад гэмт хэргийн үйл ажиллагааг урьдчилан таамаглах шаардлагатай тохиолдол

зэрэг олон шалгуур үзүүлэлтээр урьдчилан үнэлгээ өгсөний үндсэн дээр төрийн тусгай хамгаалалтад авах арга хэмжээг тодорхойлдог байна. Мөн жилийн эцэст Ерөнхийлөгчийн төлөөлөгчийн газар Ерөнхийлөгчийн агентлаг эсвэл албан

газраар дамжуулан Конгресст дараах зүйлсийг тайлагнана¹⁶ хэмээн тус тус хуульчлан зохицуулсан байдаг. Үүнд нэгдүгээрт, аюулгүй байдлыг хангахын тулд ямар шалгуураар тухайн үйл ажиллагааг үндэсний ач холбогдол бүхий онцгой үйл явдал гэж тодорхойлсон болох, хоёрдугаарт, тухайн үйл ажиллагааг үндэсний ач холбогдол бүхий онцгой үйл явдал гэж үзэх болсон шалгуур болон холбогдох мэдээлэл¹⁷ зэргийг тайлагнадаг байна. Энэ нь аливаа арга хэмжээг эрх бүхий хүн өндөр ач холбогдолтой арга хэмжээг төрийн тусгай хамгаалалтад авах, төрийн тусгай хамгаалалтын газрын үйл ажиллагаанд хууль зүйн үндэслэлгүйгээр дарамт шахалт, ажлын ачаалал үүсгэхээс урьдчилан сэргийлэх зэрэг олон эерэг үр дүнг гаргаж байна. Харин ТТХТХ-ийн хувьд аливаа арга хэмжээг ямар шалгуур үзүүлэлтээр төрийн тусгай хамгаалалтад авч байгаа эсэх, авсан тохиолдолд шалтгаан нөхцлөө хэнд, хэрхэн тайлагнах зэрэг хариуцлагын тогтолцоог давхар хуульчлан зохицуулаагүй байгааг онцлох нь зүйтэй.

Г. Барилга, тээврийн хэрэгсэл

ТТХТХ-ын ТТХТХ-ийн 8-р зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай бусад зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална” хэмээн заасан байна. Энэхүү зохицуулалтын хэрэгжилтийн дагуу Засгийн газар 2012 онд “Жагсаалт батлах тухай” 65 дугаар тогтоолоор “Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай зүйлийн жагсаалт”-ыг баталсан бөгөөд үүнд нийт 27 төрлийн барилга байгууламжийг ангилан авч, төрийн тусгай хамгаалалтад түр байх 4 төрлийн зүйлийн жагсаалтыг батлан гаргасан байна. Тус тогтоолд төрийн тусгай хамгаалалт нь байнгын ба түр гэсэн 2 хэлбэртэй байхаар зохицуулсан байх бөгөөд хамгаалалтын объектод:

- Төрийн ордон, “Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө” цогцолборыг засвар, үйлчилгээтэй байх үед Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын үйл ажиллагаагаа явуулах ордон, байр
- Олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ хийх байр, танхим

¹⁶ АНУ-ын 18 дугаартай хуулийн 3056 дугаар бүлэг /АНУ-ын Төрийн хамгаалалтын албаны эрх мэдэл, бүрэн эрх, эрх ба үүрэг хариуцлага/ <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>.

¹⁷ АНУ-ын 18 дугаартай хуулийн 3056 дугаар бүлэг /АНУ-ын Төрийн хамгаалалтын албаны эрх мэдэл, бүрэн эрх, эрх ба үүрэг хариуцлага/ <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>.

- Дайны байдал, дайн бүхий байдал, онц байдал зарласан үед төр, засгийн эрх барих дээд байгууллага, удирдлага, зэвсэгт хүчний дээд командлал байрлах тусгай байр
- Төрийн тусгай хамгаалалтын I зэрэглэлд хамрагдах хамгаалуулагчийн зорчих авто замын болон төмөр замын гүүр, гарц зэрэг орно.

Гэвч тус зохицуулалтын хүрээнд төрийн тусгай хамгаалалтад байлгах барилга байгууламжийг хэрхэн тогтоох вэ гэдэг асуудал тулгарч байна. Гадаад орны хууль тогтоомжид төрийн тусгай хамгаалалтад авах тухай Засгийн газрын тухайлан заасан барилга байгууламжийн тогтоол байхгүй байх бөгөөд ихэнхи тохиолдолд зөвхөн хуулиар тухайлан заасан хамгаалуулагч субъект буюу зөвхөн хамгаалуулах хүн байрлах барилга байгууламж, түүний нутаг дэвсгэрийг хамгаална гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, төрийн тусгай хамгаалалт бүхий барилга нь хүнээ дагасан цөөхөн тооны барилгыг хамгаалалтдаа авдаг байна. Тодруулбал, АНУ-ын 2011 оны Холбооны хамгаалалттай барилга эсхүл газрын тухай хууль-д Хамгаалалтын барилга эсхүл газар /restricted building or grounds/ гэдгийг хуулиараа дараах байдлаар тодорхойлон заасан байна.

- Цагаан ордон эсвэл түүний газар, эсвэл Дэд Ерөнхийлөгчийн албан ёсны оршин суух газар эсвэл түүний газар,
- Ерөнхийлөгч болон Нууц албаны хамгаалалтад байгаа хуулиар заасан түр хугацаагаар зочилсон эсвэл бусад этгээдийн байр, ба түүний газар,
- Улсын ач холбогдол бүхий онцгой үйл явдалтай арга хэмжээний хамгаалагдсан барилга эсвэл түүний газар хэмээн тус тус хуулиараа нарийчлан тодорхойлсон байна.¹⁸

Харин БНСУ-ын хувьд улсын нэн хэрэгцээт байгууламжийг 3 бүлэгт хуваан үздэг бөгөөд улсын нэн хэрэгцээт байгууламж гэдэг нь гадны халдлагад өртөхөд улсын аюулгүй байдал, иргэдийн ахуй амьдралд сөрөг үр дагавар авчрах нийтийн байгууламж, онгоц, усан онгоцны буудал, үйлдвэрлэлийн чухал байгууламжийг ойлгонхэмээн заасан байна ¹⁹ . Улсын нэн хэрэгцээт байгууламжийг тогтоох, хамгаалах журамд заасны дагуу хамгаалалтад байх

¹⁸ The Federal Restricted Buildings and Grounds Improvement Act of 2011 <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-9834/pdf/COMPS-9834.pdf>

¹⁹ Korean association for public security administration, vol 8.1, p.95.

байгууламжийг хамгаалалтын шаардлага, хэрэгцээгээр нь дараах байдлаар ангилан авч үзсэнийг дараах хүснэгтээс харж болно.

	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг
Байгууламж	халдлагад өртөх, үйл ажиллагаа нь алдагдах тохиолдолд нэгдсэн хамгаалалт шаарддаг ба иргэдийн амьдралд сөрөг нөлөөлөл үзүүлэх байгууламж	халдлагад өртөх, үйл ажиллагаа нь алдагдах тохиолдолд хэсэгчилсэн хамгаалалт шаарддаг ба иргэдийн амьдралд сөрөг нөлөөлөл үзүүлэх байгууламж	халдлагад өртөх, үйл ажиллагаа нь алдагдах тохиолдолд богино хугацааны нэгдсэн хамгаалалт шаарддаг ба иргэдийн амьдралд сөрөг нөлөөлөл үзүүлэх байгууламж

Харин дээрх зэрэглэлийн дагуу улсын нэн чухал байгууламжуудыг ангилдаг бөгөөд үүнийг хүснэгтээр харуулвал²⁰

Ангилал	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг
Байгууламж	<ul style="list-style-type: none"> - Төрийн ордон - Улсын их хурлын танхим - Дээд шүүх - Central Government Complex - Солонгосын төв банк - Улсыг аюулаас хамгаалах газар болон улсын нэгдсэн мэдээллийн төв 	<ul style="list-style-type: none"> - Яамд - Ерөнхий прокурор - Цагдаагийн ерөнхий газар - Цаг уурын ерөнхий газар - Солонгосын үйлдвэрлэл хөгжилийн банк - Солонгосын импорт экспортын банкны төв байр 	<ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны төв байгууллага - Улсын нэгдсэн мэдээллийн төвийн салбар - Солонгосын төв банкны салбар - Солонгосын үйлдвэрлэл хөгжилийн банкны орон нутгийн салбар - Өмнөд, хойд солонгосын хил дээр байрлах улсын байгууламж

²⁰ Korean association for public security administration, vol 8.1, p.95.

			- Нэн хэрэгцээтэй улсын болон нийтийн байгууламж
--	--	--	--

Өөрөөр хэлбэл БНСУ нь улсын хамгаалалтад байх байгууламжийг хэрэгцээ, шаардлагад нь тулгуурлан стандарт тогтоож уг стандартын дагуу хамгаалалтад байх байгууламжуудыг ангилсан байна. Үүний адилаар манай улс төрийн тусгай хамгаалалтад байх байгууламжуудын хэрэгцээ шаардлагаас хамааран ангилал тогтоож, стандарттай болох шаардлагатай байна.

Иймд дээрхи улсын жишгээс туршлага судлан ТТХтХ-д төрийн тусгай хамгаалалтад авах барилга байгууламжийн шалгуур үзүүлэлт, стандартыг тогтоох нь Засгийн газар өөрийн үзэмжээр шийдэх, хууль ёсны шалгуур үзүүлэлтгүйгээр хамгаалалтын цар хүрээг тогтоох сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзэж байна

2.2. “Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

2.2.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага

Шалгуур үзүүлэлтийн томъёолол

ТТХтХ-ийн 10-р зүйлийн 2-т “Төрийн тусгай хамгаалалтын газар хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын болон дүн шинжилгээний нэгжтэй байх бөгөөд зохион байгуулалтын бүтцийг төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн Засгийн газар тогтоох зохицуулалт хэрхэн хэрэгжиж байна вэ?

Тус эрх зүйн зохицуулалтын хүрээнд манай улсын төрийн тусгай хамгаалалтын газар нь бүтэц зохион байгуулалтын хувьд хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын болон дүн шинжилгээний нэгжээс тус тус бүрддэг байна. Гэвч практикт Засгийн газрын 2011 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 312 дугаар тогтоолын 2-т “...үүнтэй холбогдуулан Төрийн ордны холбоо, техникийн үйлчилгээг үндсэн

хөрөнгө, орон тоо, төсвийн хамт Төрийн тусгай хамгаалалтын газарт шилжүүлэх,...” гэж заасны дагуу “холбооны нэгж” тус газрын бүтцэд шинээр нэмэгдэн орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Холбооны нэгж нь төрийн тусгай хамгаалалтад байх хурлын үйл ажиллагааны холбоо, мэдээллийн технологийн техник үйлчилгээ, хэвийн ажиллагааны бэлэн байдлыг хангах чиглэлээр УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ-ын мэдээлэл технологийн нэгжтэй хамтран болон төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааны радио холбоо, мэдээлэл технологийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр ажиллаж байна. Иймд ТТХТХ-ийн 10.2-т заасан тусгай хамгаалалтын газрын нэгжид тус шинээр байгуулагдсан “Холбооны нэгж” байхгүй байх тул уг зүйл заалтыг шинэчлэн найруулж, тус заалтыг практиктай нийцүүлэх шаардлагатай тулгарч байна.

Гадаад орны туршлага болох АНУ-ын Нууц албаны бүтэц зохион байгуулалтаас²¹ дурдвал,

Нууц алба нь дараах бүтэц, зохион байгуулалттай байна.

- Санхүүгийн ерөнхий алба
- Мэдээллийн ерөнхий алба
- Хүний нөөцийн алба
- Стратеги төлөвлөгөө, бодлогын алба
- Төр, олон нийттэй харилцах алба
- Мөрдөх алба
- Мэргэжлийн хариуцлагын алба (Office of professional responsibility)
- Хамгаалалтын үйл ажиллагааны алба
- Стратегийн тагнуул ба мэдээллийн алба
- Техникийн хөгжил болон даалгавар гүйцэтгэхэд туслалцаа үзүүлэх алба
- Сургалтын алба

Нууц алба нь Төрийн тусгай хамгаалалтын чиг үүргээ дараах салбаруудаараа хэрэгжүүлнэ:

- Агаарын орон зайн аюулгүй байдлын салбар
- Мэргэн буучдын баг
- Яаралтай арга хэмжээ авах баг

²¹ АНУ-ын Нууц албаны цахим хуудас.

<https://www.secretservice.gov/sites/default/files/reports/2020-09/USSS-Office-Org-Chart-2020.pdf>

- Тагнуулын хэсэг
- Сөрөг довтолгооны баг
- Аюулыг бууруулах, эмнэлгийн яаралтай тусламжийн баг болон бусад мэргэшсэн багууд орно. Нууц алба нь 3200 тусгай ажилтан (Special agent), 1300 цэргийн албан хаагчид болон 2000 гаруй захиргааны, бусад мэргэжлийн болон техникийн туслалцаа үзүүлэх ажилтнуудаас бүрдэнэ.²² Дээрхи байдлаас дүгнэвэл мэргэжлийн хариуцлагын алба, техникийн хөгжил болон даалгавар гүйцэтгэхэд туслалцаа үзүүлэх алба байгааг онцолж Монгол Улсын ТТХГ нь эрсдлийг урьдчилан тооцоолох, түүнд тохирсон хамгаалалтын төлөвлөгөө, техник төхөөрөмжийн нээлт хийх боломжит нөхцөлөөр хангахуйц тогтолцоог бүрдүүлэх зорилгоор инновац хөгжлийн нэгжийг тусгах нь зүйтэй байж болох ч энэ талаар нарийвчлан судлах шаардлагатай.

Харин БНСУ-ын хувьд бүтэц, зохион байгуулалтын хувьд дараах албуудаас бүрддэг байна:

	Нэгж	Гүйцэтгэх ажил
Монгол	Хамгаалалт	Нууцын зэрэглэлтэй
	Үйлчилгээ	
	Захиргаа	
	Сургалт	
	Дүн шинжилгээ	
БНСУ	Дотоод хяналт	- Үйл ажиллагааны хяналт
	Аюулгүй хамгаалалтын сургалт	- Хамгаалалтын аюулгүй байдал, зохицуулалтын талаарх судалгаа - Алба хаагч болон хамгаалалтын салбарт ажилладаг алба хаагчдад сургалт хийх
	Захиргаа	- Удирдлагаар хангах
	Төлөвлөгөө удирдлага	- УИХ, улсын төсөв гэх мэт гадны үйл ажиллагаа болон байгууллага, алба хаагчдын зохион байгуулалт

²² | [United States Secret Service](#)

		- Ирээдүйд үүсч болох хамгаалалтын эрсдэл, халдлагыг тодруулах, урьдчилан хамгаалах
	Хамгаалалт	- Ерөнхийлөгч үйл ажиллагаанд оролцох явцад хамгаалах - Гадны орны тэргүүн, ЗГ-ын тэргүүний хамгаалалт
	Аюулгүй байдал хангах	- Төрийн ордон болон ойролцоох нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах - Төрийн ордны дотоод, гадаад орчинд хамгаалалт хийдэг цэрэг, цагдааг зохион байгуулж удирдах - Арга хэмжээний аюулгүй байдлыг хангах, ерөнхийлөгчийн алба хашиж байсан хүнийг хамгаалалтад авах
	Хамгаалалтыг дэмжих	- Байгууламж, хамгаалалтын тээврийн хэрэгсэл гэх мэт хамгаалалтын үйл ажиллагааг дэмжих - Төрийн үйл ажиллагаа, мэдээллийн холбоо харилцааг хангах, хамгаалалтын систем бий болгох, IT техник төхөөрөмжийн нээлт хийх

Монгол Улсын ТТХГ-ын зохион байгуулалтын бүтцийн мэдээлэл маш хомс буюу нууцын зэрэглэлд байдаг бол АНУ, БНСУ-ын зохион байгуулалт, бүтэц нь олон нийтэд ил тод байна. АНУ-ын Нууц албаны зохион байгуулалтад Мэргэжлийн хариуцлагын алба гэж байгаа бол БНСУ нь дотоод үйл ажиллагааг хянах, хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх Дотоод хяналтын алба гэсэн нэгжтэй байгааг онцлох нь зүйтэй. Харин Монгол Улсын ТТХГ-ын хяналтын механизмыг бүрэлдүүлэх бүтэц зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах тухай нарийвчлан судлах нь зохистой юм.

ТТХГ-ийн 11 дүгээр зүйлд төрийн тусгай хамгаалалтын газрын эрх, үүргийг заасан байдаг. Хуульд заасан эрхийн агуулгыг нарийвчлан үзвэл 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн тусгай хамгаалалтын үүргийн заалтуудтай агуулгын хувьд давхацсан байна. Үүнийг хүснэгтээр харуулвал:

11.1-р зүйлд заасан эрх	11.2-р зүйлд заасан үүрэг
<p>11.1.6. хамгаалуулагчид дотоод, гадаадаас ирүүлсэн бэлэг дурсгал, бусад зүйлд тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис байгаа эсэхэд мэргэжлийн болон холбогдох байгууллагаар шалгалт, шинжилгээ хийлгэх</p> <p>11.1.7. хамгаалуулагчийн хоол, хүнсний бүтээгдэхүүн, тээврийн хэрэгсэл, үйлчилгээнд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үзлэг, шалгалт хийж, дүнг холбогдох байгууллагад мэдэгдэх</p>	<p>11.2.8. төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, тээврийн хэрэгсэл, бусад зүйл, тэдгээрийн орчинд холбогдох байгууллагуудтай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах</p> <p>11.2.10. байгууллага, алба хаагчийнхаа аюулгүй байдлыг хангах</p>
<p>11.1.9. хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхим, хамгаалуулагчийн ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл болон түр байрлах орон байр, албан тасалгаанд техникийн үзлэг, шалгалт хийх</p>	<p>11.2.1. Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах</p>

Иймд ТТХГ-ын эрх үүргийг дахин ангилж, шинээр нэмэгдэж буй нэгжийн үйл ажиллагааг хуульд тусган хууль зүйн зохицуулалт практикын уялдаа холбоог хангаж, шинэчлэн найруулах шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол

ТТХГ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын төв, орон нутгийн байгууллагаас туслалцаа авах, харилцан ажиллах” хэрэгжилтийн тухайд

Тус зохицуулалтын хүрээнд Төрийн тусгай хамгаалалтын газрын хамтын ажиллагааны эрхийг хуульчлан заасан байх бөгөөд тус заалтын хэрэгжилтийн түвшин харьцангуй сайн гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалт 2016 оны долдугаар сарын 14-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо болж, улмаар дээд түвшний уулзалтыг угтан, ирэх зочид, төлөөлөгчид нь А зэрэглэлд буюу төрийн тусгай хамгаалалтад авах хүмүүс байсан тул зочдын аюулгүй байдлыг хангаж ажиллахаар ЦЕГ, ЗЦГ-тай Төрийн тусгай хамгаалалтын газар хамтарч ажиллажээ. Иймд Хууль зүйн сайдын 2015 оны А/174 дугаар тушаалаар баталсан "Нэгдсэн удирдлагын төв, Төрийн тусгай хамгаалалтын газрын Шуурхай удирдлагын штаб, Цагдаагийн Ерөнхий газрын Шуурхай удирдлагын штабын бүрэлдэхүүнд 10 ажлын дэд хэсгүүд байгуулагдан тусгайлсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж 24 цагийн турш үйл ажиллагаа хамтран явуулсан байна.²³ АСЕМ-ын үндсэн болон дагалдах арга хэмжээний хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий Тагнуулын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Онцгой байдлын газарт байрлах штабууд болон нэгдсэн хамгаалалтын байрлалуудад байрласан аюулгүй байдлын багцуудтай Онцгой байдлын албаны холбоог ашиглан холбоонд орж мэдээлэл солилцож байв. АСЕМ-ын уулзалтын үеэр Онцгой байдлын албаны нийт 1085 албан хаагч өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэн ажилласан бөгөөд хамгаалалтын болон аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх хугацаанд Нийслэлийн онцгой байдлын газрын Аврах ангийн 20 албан хаагч, 3 автомашин, 1 тийрэлтэт завь, 2 хийлдэг завьтай, Аврах тусгай ангийн 7 албан хаагч, 1 автомашин, 1 хийлдэг завьтайгаар Гачуурт-АСЕМ Вилла хотхон, АСЕМ Вилла хотхон-Маршалын гүүр, Маршалын гүүр-Сонсголон чиглэлд завьт эргүүл хийж 07 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд 3 иргэнийг аварч, 1497 иргэн, 872 автомашиныг хамгаалалтын бүсээс гаргаж Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн. Нийт 3800 гаруй сурталчилгааны материал тарааж 1200 иргэнд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх арга хэмжээг авсан бол Замын цагдаагийн газрын 60, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 34, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 17, нийслэлийн дүүрэг дэх таван цагдаагийн газар, хэлтсийн

²³Цагдаагийн байгууллага АСЕМ-ийн үеэр. <https://gogo.mn/r/6d2qy>

626, зочид төлөөлөгчдийн байрлах 36 зочид буудлын гадна талд 86 нийт 1100 орчим теле хяналтын камерыг байрлуулсан аж. Тус ажиллагаагаар тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын чиглэлийн нэгж, албан хаагчид хамтран нэг удирдлага зохион байгуулалтад орж үүрэг гүйцэтгэснээр ажил, арга хэмжээ зохион байгуулалттай, нягт, алдаа дутагдалгүй хэрэгжсэн онцлогтой байсан ба байгууллагуудын цаашдын хамтын ажиллагаа улам сайжирч, туршлага хуримтлуулсан үйл ажиллагаа болсон²⁴ тул тус заалтын хэрэгжилтийн түвшин харьцангуй сайн гэж үнэлж байна.

2.2.2.Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын эрх зүйн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол

Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрхийн хэрэгжилт оновчтой байгаа эсэх?

Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрхийг хүснэгтээр харуулвал тус хуулийн 12-р зүйлд заасан дараах байдлаар хуульчлан зохицуулсан байгааг доорх хүснэгтээс харж болно.

12 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрх

Д/д	2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн зохицуулалт	
1	Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрх /Энэ зүйлийг өөрчлөн	Төрийн тусгай хамгаалалтын газрын хүний нөөцийг бэлтгэх, зэвсэг, техникээр хангах, бэхжүүлэх талаарх саналаа Засгийн газарт танилцуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
2	найруулсан	Төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;
3		Техникийн үзлэг, шалгалт хийх зөвшөөрөл олгох;
4		Батлагдсан төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

²⁴АСЕМ-ын уулзалтын үеэр Онцгой байдлын албаны нийт 1085 албан хаагч өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэн ажиллалаа, <https://nema.gov.mn/n/18047%2016.07.19>

5		Хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу албан хаагчийг томилох, чөлөөлөх, цэргийн цол олгох, бууруулах, хураах, сэргээх, шагнаж урамшуулах, ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх;
6		Төрийн тусгай хамгаалалтад оролцож байгаа бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;
7		Байгууллагыг төлөөлөн дотоод, гадаадын байгууллагатай харилцан ажиллах

Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрхийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж буй эсэхэд үнэлэлт өгөх зорилгоор бусад ижил чиг үүрэг бүхий байгууллагын газрын даргын тухай хуулийн зохицуулалтыг харьцуулан харах нь зүйтэй. Тодруулбал, Цагдаагийн албаны тухай хуульд Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрхийг хуульчлан зохицуулсан байх бөгөөд 17 төрлийн бүрэн эрхийг хуулиар олгосон байна. Үүнд тус хуулийн 21.1.3 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, цагдаагийн хүрээний болон эргүүл, харуулын дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах” хэмээн заасан буюу үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журам, зааврыг батлах бүрэн эрхийг олгосон байна. Гэвч ТТХТХ-д ТТХГ-ын даргын бүрэн эрхэд тус зохицуулалт агуулагдаагүй байгаа бөгөөд дараах хүснэгтээр журам батлах эрхийг аль субъектэд түлхүү өгсөн байгааг харж болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасны дагуу дагалдан гарах эрх зүйн актын тухайд

д/д	Журам, зааврын нэр	Батлах субъект	Хуулийн заалт
1	Хамгаалалтын зэрэглэл тус бүрийн онцлогт тохирсон хүч хэрэгслийн хэмжээ, тэдгээрийг хамгаалалтын тухайн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулах журам	Засгийн газар	9 дүгээр зүйлийн 9.3
2	Төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам	Засгийн газар	10 дүгээр зүйлийн 10.3

3	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журам	Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар	13 дугаар зүйлийн 13.4
4	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн дүрэм	Засгийн газар	13 дугаар зүйлийн 13.5
5	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх журам	Монгол Улсын Ерөнхийлөгч	14 дүгээр зүйлийн 14.2
6	Тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газрын харилцан ажиллах, мэдээлэл солилцох	Тагнуулын ерөнхий газрын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга хамтран	18 дугаар зүйлийн 18.2
7	Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх заавар	Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран	22 дугаар зүйлийн 22.6

Дээрхи хүснэгтээс харвал ТТХГ-ын дарга нь “Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх заавар” болон “Тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газрын харилцан ажиллах, мэдээлэл солилцох” тухай журмуудыг хамтран батална гэж заасан бөгөөд бусад журам зааврыг дийлэнхи тохиолдолд Засгийн газар баталж байхаар зохицуулсан байгааг онцлох нь зүйтэй. Улмаар төрийн тусгай хамгаалалттай холбогдох аливаа дүрэм журмыг батлах эрх нь ТТХГ-ын даргын бүрэн эрхэд байхгүйгээс улбаалан тус хуулийн хэрэгжилтийн уялдаа холбоо алдагдах, аливаа журам удааширч гарах, практиктай нийцэхгүй байх зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална гэсэн боловч одоог хүртэл тус журам нь батлагдаагүй байна. Мөн өмнө нь дурдсанчлан Засгийн газар стандартгүй хүн хүч, нөөцийн баримжаагүй өөрийн үзэмжээр шийдвэр гарах тохиолдол их байгааг онцлох нь зүйтэй. Иймд газрын даргын бүрэн эрхийн тухай эрх зүйн зохицуулалтыг дахин нэг боловсруулан, шинэчлэн найруулах шаардлага тулгарч байна.

2.2.3.Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагчдын эрх зүйн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлын тухай зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэх?

ТТХтХ-ийн 13-р зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэнийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ” гэж тусгасан байдаг. Үүнээс үзэхэд, Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийг хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэн хэмээн тодорхойлсон байна. Төрийн тусгай хамгаалалтын газар нь бүтэц, зохион байгуулалтын хувьд хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын, дүн шинжилгээний болон холбооны нэгжээс бүрддэг. Нэгж бүрийн хэрэгжүүлдэг чиг үүрэг адилгүй бөгөөд хамгаалалтаас гадна өөр үүрэг гүйцэтгэдэг. Иймд, тус хэсэгт төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тодорхойлолтыг агуулгын хувьд засч, нийт алба хаагчдын чиг үүргийг хамруулан тусгах шаардлагатай. Тухайлбал, “хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа” гэснийг “төрийн тусгай хамгаалалтын газар үүрэг гүйцэтгэж байгаа” гэх зэргээр шинэчлэн найруулах нь зүйтэй.

Цааш үргэлжлүүлэн ТТХ-ын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдуулан ТТХтХ-ийн 15-р зүйлд Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх, үүргийн зохицуулалт зохистой хэрэгжиж буй эсэх талаар судлахад тус зүйл заалт дээр эрх, үүргийг хамтад нь тусгасан нь эрх, үүргийн хоорондох ялгаа заагийг ойлгоход асуудалтай байгааг онцлох нь зүйтэй. Тиймээс эрх, үүргийг салгаж доорх байдлаар ангилвал зохимжтой.

Алба хаагчийн эрхийн хувьд:

- төрийн тусгай хамгаалалттай холбогдсон хүсэлт, шаардлагыг иргэд, албан тушаалтанд тавих, дэмжлэг туслалцаа авах, төрийн тусгай хамгаалалтын бүс, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх бичгийг шалгах, эд зүйлд үзлэг хийх, хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлээс сорьц авч шинжилгээ хийх, ашиглахыг хориглох, төрийн тусгай

хамгаалалтын бүсэд ажиллах бусад байгууллагын ажилтанд зааварчилгаа өгөх, хяналт тавих

- төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд сэжиг бүхий этгээд илэрвэл түүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, уул этгээдийг 2 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис илэрвэл хураан авах, холбогдох байгууллагад шилжүүлэх;
- хамгаалуулагчид бодитой аюул учирсан тохиолдолд шаардлагатай бол хуулиар хориглосноос бусад автотээврийн хэрэгсэл болон бусад уналга дайчлах;
- төрийн тусгай хамгаалалтын ажлын шаардлагаар байгууллага, иргэдийн телефон утсаар үнэ төлбөргүй, нийтийн холбооны хэрэгслээр дараалал харгалзахгүй үйлчлүүлэх, байр, орон сууцанд эзэмшигчийн зөвшөөрлөөр нэвтрэн орох, үзлэг хийх;
- албан үүргээ гүйцэтгэж байхдаа зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах, тогтоосон журмын дагуу хэрэглэх;

Харин үүргийн хувьд:

- өргөсөн тангарагтаа үнэнч байх;
- удирдах байгууллагын шийдвэр, захирах даргын тушаалыг биелүүлэх;
- хамгаалуулагчийн хувийн нууцыг чанд хадгалах;
- хамгаалалт, үйлчилгээний ажлын мэдлэг, тусгай бэлтгэлээ байнга дээшлүүлж, шударга, санаачилгатай ажиллах гэх зэргээр эрх, үүргийг салгаж зааж өгсөнөөр хууль хэрэглэхэд тодорхой, ойлгомжтой болно гэж үзэж байна. Мөн Төрийн тусгай хамгаалалтын газартай төсөөтэй чиг үүрэг бүхий байгууллага болох Тагнуулын байгууллагын тухай хуульд тагнуулын ажилтны эрх, үүргийг тусдаа зүйл заалт дээр тусгаж өгсөн байгаа нь алба хаагчийн эрх үүргийг тодотгон албан үүргээ биелүүлэхэд ойлгомжтой байдлыг бий болгож байна.

Үүнээс сөрөг үр дагавартай байх магадлалтай ба онцолж дурдвал зохистой зүйл заалтуудыг тусгайлан сонгон авч дэлгэрүүлэн судаллаа. Тус хуулийн 15.1-т заасан “Төрийн тусгай хамгаалалттай холбогдсон хүсэлт, шаардлагыг иргэд, албан тушаалтанд тавих.....төрийн тусгай хамгаалалтад

авсан барилга, бусад зүйлд нэвтрэн орох хүмүүсийн үнэмлэх, нэвтрэх бичгийг шалгах, эд зүйлд үзлэг хийх...хяналт тавих” гэж заасан байх бөгөөд тус хэсэг дээр хүний биед үзлэг хийх гэж тусгаагүй байна. Харин тус зүйлийн 2 дахь хэсэгт “төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд сэжиг бүхий этгээд илэрвэл түүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, уул этгээдийг 2 цаг хүртэл хугацаагаар түр саатуулах, зэвсэг, зэвсгийн чанартай зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис илэрвэл хураан авах, холбогдох байгууллагад шилжүүлэх” гэж зааснаас харахад зөвхөн сэжигтэй этгээдийн биед үзлэг хийхээр ойлгогдож байна. Тиймээс тус хэсэг дээр нэвтрэн орох хүмүүсийн бие, эд зүйлд үзлэг хийх гэж тусгах шаардлагатай байна.

Тус заалтын 15.3-дахь хэсэгт “Хамгаалуулагчид бодитой аюул учирсан тохиолдолд.....бусад уналга дайчлах” гэж заасан байна. Үүнээс харахад бодитой аюул гэдэгт ямар нөхцөл байдлыг хамааруулж ойлгож байгаа нь тодорхойгүй байна. Иймд бодитой аюул гэдгийг юу гэж ойлгож байгааг судлан авч үзэх шаардлагатай байна.

Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар²⁵ дээр халдлагад хамаарах нөхцөлийг халдлага өөрийн объектив шинжээрээ нийгэмд аюултай байх, довтолгоон нь бодитой байх гэж тодорхойлсон байна. Бодитой довтолгоон²⁶ гэдгийг довтолгоон шууд эхлэх гэж байгаа нь тодорхой болсон, эхэлсэн, эсхүл эхлээд үргэлжилж байхыг хэлнэ гэжээ. Дүгнэвэл, бодитой аюул гэдгийг тодорхой нарийвчлан зааж өгөх эсхүл хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж өгөх шаардлагатай байна.

15.4-т “төрийн тусгай хамгаалалтын.....байгууллага, иргэдийн телефон утсаар үнэ төлбөргүй, нийтийн холбооны хэрэгслээр дараалал харгалзахгүй үйлчлүүлэх,.....үзлэг хийх” гэж заасан байх ба тус зүйл заалт нь өнөөгийн нийгэмд хэрэгжихэд учир дутагдалтай байна.

ТТХтХ нь 1995 онд батлагдсан бөгөөд тухайн үеийн нийгэм, цаг үеийн байдал, хөгжлийн түвшин нь өнөө үеээс нилээдгүй ялгаатай байсан мөн тухайн цаг үед хэрэглэгддэг байсан нийтийн холбооны хэрэгсэл болон телефон утас нь

²⁵ Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар. 2010 он.

²⁶ Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц. 2017 он.

одоо цагт хэрэглээнээс гарсан юм. Иймд тус хэсгийг өнөөгийн нийгэм, цаг үетэй уялдуулж шинэчлэн найруулах шаардлагатай байна мөн хамгаалалтын үйл ажиллагаанд зайлшгүй тохиолдолд иргэдийн хувийн эд зүйлийг дайчлан ашиглахад иргэдэд учирсан хохирлыг барагдуулах талаарх зохицуулалтыг тусгах нь зүйтэй .

15.5-т “албан үүргээ гүйцэтгэж байхдаа зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч явах, тогтоосон журмын дагуу хэрэглэх” гэж мөн 22.6-д “Төрийн тусгай хамгаалалтад хэрэглэх зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх зааврыг Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Улсын ерөнхий прокурортой хамтран батална” гэж тус тус заасан байдаг бөгөөд тус хуульд 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар Тагнуулын байгууллагаас тусдаа бие даасан агентлагийн статустай болсон билээ. Тэгвэл тус хуулийн зүйл заалтыг үндэслэн 2015 онд буюу Төрийн тусгай хамгаалалтын газар нь Тагнуулын байгууллагын харъяа байх үед Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий прокурорын хамтаар Төрийн тусгай хамгаалалтад зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг²⁷ баталсан байна. Тус зааврын 1.6-д “Цаг хугацаа, нөхцөл байдлын хувьд хууль тогтоомжид заасан журмыг хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, хамгаалуулагч, хамгаалж байгаа объектод аюул тулгарсан тохиолдолд алба хаагч галт зэвсэг, хүйтэн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэж болно” гэж заасан байна. Иймд уг зааварт нөхцөл, чиг үүрэг гэх зэрэг тусгах шаардлагатай бүхий л зүйлийг нарийн зааж тусгаж өгсөн байх бөгөөд хуулийн хэрэгжилтэд сөрөг үр дагаваргүй байна.

Харин АНУ-ын туршлагаас үзэхэд тусгай алба хаагчийн эрх үүргийн дараах байдлаар тусган зохицуулсан байна.

Албан хаагчийн эрх, үүрэг²⁸

(1)-тай холбоотой мөрдөн байцаалт явуулах:

(А) хууль бус паспорт, виз олгох, ашиглах;

²⁷ Төрийн тусгай хамгаалалтад зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар. 2015 он.

²⁸ §2709. Special agents, 22 USC 2709: Special agents
[https://uscode.house.gov/view.xhtml?req=\(title:22%20section:2709%20edition:prelim](https://uscode.house.gov/view.xhtml?req=(title:22%20section:2709%20edition:prelim)

- (Б) Төрийн захиргааны байгууллагын хөтөлбөр, чиг үүрэг, эрх мэдэлтэй холбоотой эсвэл тэдгээртэй холбоотой хувийн мэдээллийг хулгайлах, бичиг баримтын залилангийн хэргийг тодруулах
- (В) АНУ-ын цэргийн төлөөлөгчийн газар болон холбогдох оршин суух газруудад хамаарахаас бусад тохиолдолд АНУ-ын тусгай тэнгисийн болон нутаг дэвсгэрийн харьяаллын хүрээнд үйлдэгдсэн холбооны гэмт хэргийг шалгах (18 дугаар зүйлийн 7(9) хэсэгт тодорхойлсон);
- (2) эрэн сурвалжлах, баривчлах зөвшөөрөл авах, тушаал гүйцэтгэх, түүнчлэн зарлан дуудах хуудас ашиглах;
- (3) Дараах тохиолдолд аюулгүй байдал, аюулгүй байдлыг хангахтай шууд холбоотой хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлэх хамгаалах, гүйцэтгэх:
- (А) Гадаад улсын тэргүүн, гадаадын засгийн газрын албан ёсны төлөөлөгчид болон АНУ-д ирсэн бусад хүндэт зочид;
- (Б) Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн нарийн бичгийн даргын орлогч болон АНУ-ын Засгийн газрын АНУ-д болон гадаадад байгаа албан ёсны төлөөлөгчид;
- (В) (А) эсвэл (В) дэд зүйлд заасан хүмүүсийн ойрын гэр бүлийн гишүүд;
- (Г) АНУ дахь гадаад төлөөлөгчийн газар (энэ нэрийн 4302(a)(4)[1]-д тодорхойлсон) болон олон улсын байгууллагууд (энэ нэрийн 4309(b) хэсэгт тодорхойлсон);
- (Д) аюул заналхийллийн үнэлгээний үндсэн дээр Сайдын албан тушаалыг дуусгавар болгосноос хойш 180 хүртэлх хоногийн хугацаанд хамгаалалах
- (Е) Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийн зарлигийн дагуу томилогдсон Засгийн газрын сайдаар томилогдсон хүн
- (4) Сайдын болон Ерөнхий прокурорын баталсан журмын дагуу энэ зүйлд заасан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд галт зэвсэг авч явах, хэрэглэх
- (5) Гэмт хэрэг хийсэн гэх үндэслэлтэй хүнийг баривчлах;
- (3) Галт зэвсэг авч явах, ашиглахтай холбоотой журмыг Сайдын зөвшөөрлийн дагуу Ерөнхий прокурор батална.

Дээрхи АНУ-ын тусгай алба хаагчийн эрх үүргийн зохицуулалтаас дүн шинжилгээ хийвээс алба хаагч нь мөрдөн байцаалт явуулах, гэмт хэргийг шалгах мөшгөх зэрэг хамгаалахаас гадна өөр чиг үүрэг бүхий эрх үүргийг давхар хэрэгжүүлдэгээрээ онцлогтой байна.

Мөн ТТХтХ-ийн 13-р зүйлийн 2 дахь хэсэгт “төрийн тусгай хамгаалалтын албанд 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, ял шийтгэлгүй, Монгол улсын иргэнийг ажиллуулна.” гэж заасан.

Төрийн албаны тухай хуулийн 13.1-т зааснаар “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь төрийн тусгай алба хаагч мөн” гэснийг үндэслэн Төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл заалтаас үзэхэд Төрийн албаны тухай хуулийн²⁹ 10-р зүйлд Төрийн албан тушаалын ангилал, төрлийг заасан байдаг бөгөөд 10.1.2-т төрийн захиргааны албан тушаал; 10.1.3-т төрийн тусгай албан тушаал гэж мөн хуулийн 10.3-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ.” гэж заажээ. Иймд тус зүйл заалтыг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагч нь төрийн жинхэнэ алба хаагчид хамаарч байна. Тиймээс цааш үргэлжлүүлэн төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах шаардлагыг авч үзье.

Төрийн албаны тухай хуулийн 22-р зүйлд төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагыг тусгасан байдаг бөгөөд үүнд “Монгол Улсын иргэн байх, дээд боловсролтой байх, эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх, монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх, сэтгэцийн өвчин, эмгэггүй байх, хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх” гэж заасан байдаг бол уг хуулийн 23.1-т “Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно.” гэж заасан байх бөгөөд өөрөөр хэлбэл хуулиар зохицуулах ёстой хэм хэмжээ байтал Засгийн газрын журмаар зохицуулж байгаа нь Төрийн албаны тухай хуультай нийцэхгүй байна.

Мөн Засгийн газрын 50-р тогтоолд Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмын 3.1.4-т “гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй байх” гэсэн нийтлэг шаардлагыг тусгасан байна. Харин ТТХтХ-д заасан алба хаагчид

²⁹ Төрийн албаны тухай хууль. 2017 он.

тавигдах шаардлагад ял шийтгэлгүй гэж тусгасан байгаа нь тодорхойгүй байх ба зөрчил гаргаж шийтгүүлж байсан иргэд тус байгууллагад алба хаах боломжгүй мэт эргэлзээтэй байдал үүсгэж байна. Тиймээс уг хэсгийг найруулан өөрчилж эрүүгийн ял шийтгэлгүй гэх утга агуулгыг тусгах шаардлагатай байна.

ТТХТХ-ийн 13-р зүйлийн 4 дэх хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална гэх заалт хэрхэн хэрэгжиж буй эсэх?

Тус зүйл заалтыг үндэслэн Засгийн газраас “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журам бүхий 50-р тогтоолыг 2021 оны 3-р сарын 3-ны өдөр баталсан байна. Уг тогтоолын 4-р бүлэгт Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэнд тавигдах шалгуур үзүүлэлтийг тусгасан байдаг бөгөөд тухайлбал: 4.1.1-т Бие бялдар, гоозүйн шалгуур үзүүлэлт гэсэнд:

- А) бие эрхтний болон нүүрний хэлбэр төрхийн илэрхий өөрчлөлт, гэмтэл согоггүй, бие бялдрын зөв хөгжилтэй байх;
- Б) биеийн ил харагдах хэсэгт шарх сорвигүй, шивээсгүй байх;
- В) биеийн өндөр эрэгтэй 175 см, эмэгтэй 166 см-ээс багагүй байх гэж заасан байна.

Монгол улсын Үндсэн хуулийн³⁰ 10.2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж мөн хуулийн 10.4-т “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж тус тус заасан байдаг. Мөн Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох Хүний эрхийн түгээмэл тунхаглалын³¹ 21.2-т “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй” гэж заасан байна. Үүнээс харахад Засгийн газрын 50-р

³⁰ Монгол улсын Үндсэн хууль. 1992 он.

³¹ Хүний эрхийн түгээмэл тунхаглал.

тогтоолын 4.1.1-т тусгасан бие бялдар, гоозүйн шалгуур үзүүлэлт нь Үндсэн хуулиар хамгаалсан хүний эрх, эрх чөлөөнд харшилж байгааг онцлох нь зүйтэй.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 23.1-т “Төрийн улс төрийн болон тусгай албан тушаалд тавих тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно” гэж заасан байх бөгөөд ТТХтХ-ийн 13.4-т “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэсэн нь Төрийн албаны тухай хуультай нийцэхгүй байна. Холбогдох хуулиар тогтооно гэж заасан байтал Засгийн газрын журмаар баталж байгаа нь асуудалтай байна.

Дээрхээс дүгнэвэл хүний эрхийн хэрэгжилтийн түвшинд практикт сөрөг үр дагавар үүсгэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.1-т заасан хуулийн төслийн агуулгын нийтлэг шаардлага болох “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх” шаардлага, зарчмыг зөрчиж байна. Мөн хүний эрхийг хязгаарлах үндэслэл, журмыг байгууллагын даргын саналын хүрээнд тогтоож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг зөвхөн хуулиар тогтоох зарчмыг алдагдуулж байна.

ТТХтХ-ийн 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын газрын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно” мөн **13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт** “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ” гэж заасан нь эрх зүйн үндэслэлтэй эсэх?

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч “цэргийн цол, дүрэмт хувцас” хэрэглэх тухайд

Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагчид цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэх нь бусад холбогдох хууль тогтоомж, журамтай нийцэж байгаа эсэхийг судлах нь зүйтэй. ТТХтХ-ийн 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын газрын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно” мөн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ” гэж тус тус заасан.

Мөн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн МУ-ын Ерөнхийлөгчийн 136 дугаар зарлигын дагуу батлагдсан "Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам"-ын 1.4-д төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид цэргийн цол олгохоор тогтоосон бөгөөд уг журмын 5.1-т "Төрийн цэргийн болон тагнуул, төрийн тусгай хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дарга, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, төрлийн цэргийн командлагч Цэргийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасан цэргийн цолыг олгоно"³² гэж заасан. Тиймээс төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэх эрх зүйн үндэслэлтэй байна гэж үзлээ.

Үүнд үндэслэн ТТХтХ нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуультай нийцэж буйг шалгавал; Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3-р зүйлд цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн төрлийг заасан байх бөгөөд үүнд, "цэргийн жинхэнэ алба болон тагнуул, **төрийн тусгай хамгаалалт**, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан; мөн хуулийн 4-р зүйлийн 4 дэх хэсэгт цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах алба хаагчид "тагнуулын болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын генерал, офицер, ахлагч" гэж тусгасан байдаг. Үүнээс дүгнэвэл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдыг тусгасан байх бөгөөд уг хуультай нийцэж байна.

Хоёрдугаарт, ТТХтХ нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуультай нийцэж буйг шалгавал; Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4-р зүйлд заасан хуулийн үйлчлэх хүрээнд 4.3.4.улсын хил, онц чухал объектыг хамгаалах; 4.3.5.орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд оролцох; гэж тусгасан байх бөгөөд ТТХтХ-ийн 8.1.1-т "Монгол улсын Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц, төрийн харш, гадаадын дээд, өндөр хэмжээний зочдын байрлах зочид буудал"-ыг Төрийн тусгай хамгаалалтад авахаар заасан байгаа нь онц чухал объектын хамгаалалт юм. Мөн ТТХтХ-ийн 5.1-т "гадуур хамгаалалт гэж хамгаалуулагчийг үзвэр, үйлчилгээ, олон нийтийн болон бусад арга

³² Цэргийн албаны тухай хуулийн 26.3. Цэргийн байгууллагын дарга, төрлийн цэргийн командлагч нь дараахь цэргийн цолыг олгоно: Үүнд: "Хурандаа" цолноос бусад офицерын цолыг(26.3.1), ахлагчийн анхны болон "сургагч ахлагч", "тэргүүн ахлагч" цолыг(26.3.2.)

хэмжээнд оролцох, нийслэл хот, орон нутагт явах үед тэдний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тодорхой орчин, нутаг дэвсгэрт төрийн тусгай хамгаалалтын хүч хэрэгслээр ил хэлбэрээр зохиож байгаа хамгаалалт” гэж заасан байгаагаас харахад ТТХГ-ын алба хаагчид гадуур хамгаалалтад оролцохдоо орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд оролцох чиг үүрэгтэй байна. Иймд цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дээр дурдсан холбогдох зүйл заалттай нийцэж байна.

Гадаадын зарим орнуудын Төрийн хамгаалалтын алба хаагчдын статусыг тоймлон авч үзвэл ОХУ³³, БНХАУ³⁴-ын хувьд алба хаагчид нь цэргийн алба хаагч гэх статустай байх бөгөөд АНУ-ын хувьд Хамгаалалтын ажилтнуудын нэг хэсэг нь иргэний тусгай алба хаагч, зарим нь Холбооны нийслэлийн Колумбиа тойрог буюу Вашингтон хотын цагдаагийн газрын алба хаагчийн статустай байдаг байна. Харин Япон улсын хувьд Төрийн тусгай хамгаалалттай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллага болох Аюулгүй байдлын ажиллагааны газар нь Цагдаагийн агентлагийн бүтцийн нэгж байдаг бол БНСУ-ын хувьд Ерөнхийлөгчийн хамгаалалтын газар³⁵ АНУ-ын Нууц албаны³⁶ загвараар байгуулагдсан, улсын ерөнхийлөгчид шууд захирагдах, иргэний тусгай албаны статустай байна.

Дээрхээс харвал, тухайн улсын тогтолцооны онцлогоос хамааран төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдын статус нь тодорхойлогдож байна. Манай улсын хувьд хуучин ЗХУ-ын туршлагад тулгуурлан төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид нь цэргийн алба хаагчийн статустай байгаа нь төр, эрх зүйн түүхэн замнал болон улс төрийн тогтолцооны онцлогтой холбоотой бөгөөд ТТХТХ-ийн дээрх 2 зүйл заалт нь бусад холбогдох хууль тогтоомж, журамтай нийцэж байх бөгөөд ТТХГ-ын алба хаагчид нь цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэх хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол

³³ ОХУ-ын Холбооны хамгаалалтын алба (ХХА)-ны цахим хуудас <http://www.fso.gov.ru/struktura/p8.html> хандсан 2022.04.04

³⁴ The State Council, People's Republic of China LAWS & REGULATIONS - ARCHIVE (www.gov.cn) хандсан 2022.04.04

³⁵ Ерөнхийлөгчийн хамгаалалтын газрын цахим хуудас (Англи хэл дээр) <http://www.pss.go.kr/site/main/index002> хандсан 2022.04.04

³⁶ U.S. Secret Service, <https://www.secretservice.gov/data/about/OrgChart.pdf> хандсан 2022.04.04

ТТХтХ-ийн 10-р зүйлийн 3 дахь хэсэгт Төрийн тусгай хамгаалалтын газар туг, бэлгэ тэмдэгтэй байх зохицуулалт хэрэгжиж чадсан эсэх?

Тус заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийвээс, ТТХтХ-д Төрийн тусгай хамгаалалтын газар туг, бэлгэ тэмдэгтэй байна, туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Засгийн газрын 1995 оны 127 дугаар тогтоолоор³⁷ ТТХГ-ын бэлгэ тэмдгийн тодорхойлолт, бэлгэ тэмдгийг хэрэглэх журмыг баталсан байдаг хэдий ч тус байгууллагын туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварыг хэрэглэхийг хориглосон заалтыг хуульчлан тусгаагүй байна. Ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагын хуулийг жишээ болгон дурдвал, Цагдаагийн албаны тухай³⁸ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Иргэн, хуулийн этгээд цагдаагийн албаны туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварын туг, бэлгэ тэмдэг хэрэглэхийг хориглоно” гэж заасан байна. Туг, бэлгэ тэмдэг нь тухайн байгууллагыг илэрхийлэх гол үнэт зүйл байдаг бөгөөд тэдгээрийг бусад хүн, хуулийн этгээд, өөр байгууллагууд ижил төстэйгөөр ашиглах нь хамгаалалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулж иргэд, хамгаалуулагчийг төөрөгдөлд оруулах эрсдэлтэй.

Хэдийгээр Төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдэгтэй ижил төстэй туг, бэлгэ тэмдэг хэрэглэж хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц байдлаар ашиглагдаж байсан тохиолдол бүртгэгдээгүй ч төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварын туг, бэлгэ тэмдэг хэрэглэхийг хориглосноор практикт хойшид учирч болзошгүй аливаа сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдэх учиртай. Иймд, ижил загварын туг, бэлгэ тэмдэг хэрэглэхийг хориглох заалт хуульд тусгах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол

ТТХтХ-ийн 16-р зүйлд заасан Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа хэрхэн хэрэгжиж буй эсэх?

³⁷ Засгийн газрын 127 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт.

³⁸ Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он.

Тус заалтын 16.1-дэх хэсэгт “Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна” гэж заасан боловч Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааг тодорхой тусгаж өгөөгүйгээс алба хаагчийн эрх ашиг, албан үүргээ биелүүлэх баталгаа хангагдахгүйд хүрэх эрсдэлтэй байгааг дурдах нь зүйтэй. Иймд жишээ болгон Цагдаагийн албаны тухай хуулийг сонгон судаллаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86.1-т “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно” мөн тус хуулийн 86.3-т Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно:

- 86.3.1.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;
- 86.3.2.хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;
- 86.3.3.хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү гэж заасан.
- 86.9.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлнэ гэж тус тус заажээ.

Уг зүйл заалт дээр ямар хэмжээний хохиролд хэр хэмжээний нөхөн олговор олгохыг тодорхой тусгаж заасан байна. Тиймээс ТТХтХ-ийн тус хэсгийг нарийвчлан тодорхойлж, алба хаагчид учирсан хохирлыг шийдэх эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Мөн тус зохицуулалтын 16.11-дэх хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно” гэж заасан байх бөгөөд тус хэсэгт барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан гэж тусгасан байгаа хэдий ч практикт төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нар нь тойрох зарчмаар гадна

хамгаалалтад ээлжлэн ажилладаг туршлага тогтсон. Тиймээс нийт хамгаалалтын алба хаагчдын эрх ашгийг тэгш хангах үүднээс тус зүйл заалт дээр гадуур хамгаалалтыг нэмж нийт хамгаалалтыг хамруулж тусгах шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол

ТТХтХ-ийн 17-р зүйлийн 3 дахь хэсэгт “Шаардлагатай тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амралтын цагийг хязгаарлах буюу илүү цагаар ажиллуулж байгаа зохицуулалтын хэрэгжилтийн тухайд.

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь алба хаагч болохын сацуу хүн гэх субъектийн хувьд Үндсэн хуульд заасан суурь эрхүүдийг эдлэх ёстой билээ. Хөдөлмөрийн тухай хуулийн³⁹ 91-р зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар “улс орныг батлан хамгаалах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгэх” тохиолдолд илүү цагаар ажиллаж болохоор заасан байна. Иймд энэ нөхцөлд алба хаагч нь илүү цагаар ажилласан ч Үндсэн хуульд заасан суурь эрх хамгаалагдсан байх ёстой. Тиймээс энэ асуудлыг нухацтай авч үзэх шаардлага тулгарч байна.

ТТХтХ-ийн 17-р зүйлийн 3 дахь хэсэг нь Хөдөлмөрийн тухай хуультай нийцэж буй бөгөөд аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол зэргээс улбаалж хүний эрхийг зарим тохиолдолд хуулиар хязгаарлаж болдог байна. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29-р зүйлд “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана” гэж заажээ. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын актын 19-р зүйлд мөн хүний эрхийн хязгаарлалтын заалт оржээ⁴⁰. Эдгээрээс гадна үндэсний эрх зүйн хүрээнд Үндсэн хуулийн түвшинд хүний эрхийг хуулиар хязгаарлаж болох заалтууд байдаг. Тухайлбал, Үндсэн хуулийн 18-р зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар “... Монгол Улсын нэгдэн орсон олон

³⁹ Хөдөлмөрийн тухай хууль.

⁴⁰ Эрхийг эдлэх нь онцгой үүрэг хариуцлагаас ногдуулна. Энэ нь гагцхүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэдгээр нь а/ бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаас

улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно” хэмээн заасан тул хүний салшгүй эрхийг хязгаарлах тохиолдлыг авч үзэж байгаа бөгөөд ямар ч нөхцөл байдал үүссэн гэсэн амьд явах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, эрүү шүүлтээс ангид байх эрх чөлөөний заалтыг хөндөхгүй байхаар тогтоожээ⁴¹.

Хүний эрхийн хязгаарлалттай холбоотой асуудал нь гагцхүү парламентаас гаргасан хуулиар л хязгаарлах явдал тул амралтын хугацаанаас шаардлагатай тохиолдолд хязгаарлана гэж ТТХТХ-д хуульчлан зохицуулсан нь хууль зүйн зохих шаардлагыг хангасан байна. Иймд албан хаагчдын эрхийг хязгаарлахдаа суурь эрх болох амьд явах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, эрүү шүүлтээс ангид байх эрх чөлөөний эрхүүдийг ямарч тохиолдолд хязгаарлаж болохгүй. Түүнчлэн “шаардлагатай тохиолдол” гэж юуг ойлгох нь ойлгомжгүйн улмаас төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдыг онцийн шаардлагагүй үед илүү цагаар ажиллуулах эрсдэл үүсэх магадлалтай. Мөн эрхийг хязгаарласан тохиолдолд хэрхэх тухай зохицуулалт агуулаагүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд хүндрэл учруулах, ойлгомжгүй байдал үүсгэх эрсдэлтэй байгааг дурдах нь зүйтэй. Иймд тус хуулийн хэрэгжилтийн явцад төрийн тусгай албан хаагчдыг илүү цагаар ажиллуулсан тохиолдолд алба хаагчид ямар урамшуулал, хангамж олгох, илүү цагаар ажиллуулахдаа хэр хугацаанд ажиллуулах зэргийг хуульд тусгаж өгөн алба хаагчдын эрх ашгийг хангах шаардлагатай. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 87.5-д “Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно” гэж зааснаас жишээ болгон ТТХ-ын алба хаагчийг илүү цагаар ажиллуулсан тохиолдолд хангамж тогтоох нь зүйтэй.

⁴¹ Нийгмийн хэв журам ба хүний эрх, Цагдаагийн байгууллагын албан хаагчдын гарын авлага, https://nhrcm.gov.mn/media/documents/1365649162_niigmiin_hev_juram_ba_hunii_erh.pdf

Шалгуур үзүүлэлтийн томьёолол

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх тухай зохицуулалтын хэрэгжилт хангагдаж байгаа эсэх?

ТТХТХ-ийн 22-р зүйлийн 2 дахь хэсэгт зэвсэггүйгээр тулалдах мэхийг хэрэглэх тохиолдлуудыг хуульчлан зохицуулсан байна. Иймд юун түрүүнд зэвсэггүйгээр тулалдах мэх гэдэг ойлголтыг тодруулах шаардлагатай. Төрийн тусгай хамгаалалтад зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврын 1.4.10-т “зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх” гэж хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахгүйгээр бие хамгаалах урлагийн төрлөөр зэвсэггүйгээр довтлох, хамгаалах, няцаах, барьж хүлэх зэрэг” аргыг хэлнэ гэж тодорхойлжээ. Гэсэн хэдий ч алба хаагч зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэсний үр дүнд иргэний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд ямар арга хэмжээ авах, хэрхэн хохирлыг барагдуулах талаарх зохицуулалт байхгүй байгааг онцлох нь зүйтэй.

Тус зааврын 8 дахь хэсэгт Зэвсэггүйгээр тулалдах мэхийн талаар дэлгэрэнгүй тусгасан байна. Тухайлбал 8.1-т “Хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэнд болон төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд халдсан этгээдийн эсрэг алба хаагч албадан саатуулах үүргээ өөр аргаар биелүүлэх боломжгүй бол зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэж болно” гэж мөн алба хаагчийн ямар тохиолдолд зэвсэггүйгээр тулалдах мэхийг хэрэглэх, ямар тохиолдолд хориглох зэргийг тодорхой тусгасан байна.

Монгол Улсын дотоодын эрх зүйн орчны жишээ болгон Цагдаагийн алба хаагчийн зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх заавраас⁴² дурдах нь ач холбогдолтой. Тус зааврын 2 дахь хэсэгт зэвсэггүйгээр тулалдах мэх гэдэгт “мэхний үйлдлийг урьдчилан тодорхойлох боломжгүй боловч энэ журмын 238.3.1-т заасан тохиолдолд бие хамгаалах урлагийн мэхээр тулалдах, довтлох, хамгаалах, няцаах, баривчлах, хүлэх, боох, тонгоргох, өчих гэх мэтээр биеийн хүчээр гүйцэтгэх үйлдэл” гэж тусгажээ. Мөн тус журамд зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэсэн тухай илтгэх талаар зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

⁴² Нийгмийн хэв журам ба хүний эрх. 2012 он.

5.1. Цагдаагийн алба хаагч тусгай мэх хэрэглэсэн тухайгаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 233.6.1-т заасан болон дараах тохиолдолд шууд захирах даргадаа нэн даруй илтгэж бичгээр танилцуулна:

а/ бусдад гэмтэл учирсан

б/ гомдол гаргасан

5.2. Илтгэх хуудсанд тусгай мэх хэрэглэсэн үндэслэл, энэ журмын 238.4-т заасан хүчин зүйлс, тусгай мэх хэрэглээгүйгээс учрах болон учирсан хор уршиг, хэрэглэсэн тусгай мэх, бусдад болон өөрт гэмтэл учирсан бол авсан арга хэмжээ зэргийг дэлгэрэнгүй бичнэ гэж заажээ. Үүнээс дүгнэвэл Цагдаагийн алба хаагчийн зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх заавар, журамд хохирол учирсан тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгаж өгсөн нь давуу талтай байна.

Харин гадаад орны хувьд жишээ болгон АНУ-ыг сонгон судалсан бөгөөд АНУ-д зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэхийг “Аюулгүйн тактик ашиглах” гэж нэрлэдэг байна. АНУ-ын хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон агентууд нийтийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ ослыг үр дүнтэй хянах тактик, арга техникийг ашиглахыг эрэлхийлж, санамсаргүй гэмтэл, эд хөрөнгийн ноцтой хохирол учруулах эрсдэлийг бууруулахын тулд аюулгүйн тактик ашиглах ёстой гэж үздэг.⁴³ Хууль сахиулах байгууллагын ажилтнууд нь хүч хэрэглэхээс зайлсхийхийн тулд ухрах үүрэг хүлээхгүй бөгөөд заналхийллийг зогсоохын тулд хүч хэрэглэхээс өмнө довтолгоог хүлээх шаардлагагүй гэсэн зарчмыг тусгаж өгсөн онцлогтой байна.

Мөн аливаа заналхийллээс олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд хүч хэрэглэснээс үүдэн гарсан бэртэл гэмтэл авсан, шархадсан, мөн эмнэлгийн тусламж авах шаардлагатай аливаа субъектэд боломжтой бол анхан шатны тусламж үзүүлэх, эмнэлгийн тусламж дуудах, эмнэлэгт хүргэж өгөх үүргийг хүлээхээс гадна хүч хэрэглэсэн тухай бүртээ холбогдох удирдлагадаа заавал мэдэгдэх үүрэгтэй байдаг ба уг үүргээ биелүүлээгүй алба хаагчид захиргааны эсхүл эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Иймд дээрх дотоодын болон гадаадын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын сайн туршлагыг авч ТТХТХ-д тусган, журмаар нарийвчлан дэлгэрэнгүй зохицуулах нь Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагчдад,

⁴³ Policy on the use of force, Homeland security. 2018.

бусад хууль хэрэглэгчдэд, эрсдэлт бүхий иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэхээс урьдчилан сэргийлж, хууль хэрэгжилтийн түвшинд эерэг үр дагавар үүсэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол

Алба хаагчийн галт зэвсэг хэрэглэх тухай зохицуулалт хэрхэн хэрэгжиж байна вэ?

ТТХтХ-ын 22-р зүйлийн 5 дахь хэсэгт “Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь эмнэлгийн байгууллага, захирах даргадаа, захирах дарга нь прокурорт тус тус нэн даруй мэдэгдэнэ” гэж заасан байна. Тус заалтын агуулгад дүн шинжилгээ хийвээс зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс болж зөвхөн хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирсан бол мэдэгдэж, хохирол учраагүй тохиолдолд мэдэгдэхгүй байх эрхтэй байж болох тухай давхар утгыг илэрхийлж байна.

Энэ тухай бусад дотоодын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсныг судлах шаардлагатай байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд хэрхэх, хэнд мэдэгдэх тухай эрх зүйн орчныг харьцуулан судлах нь зүйтэй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 298-р зүйлийн 5 дахь хэсэгт “Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн гэмтсэн тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ. Галт зэвсэг хэрэглэсэн тохиолдол бүрд прокурор, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ” мөн 6 дахь хэсэгт “Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална” хэмээн заасан байна. Тус заалтуудаас үзэхэд галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд хэрхэх тухай ТТХтХ-аас ялгамжтай зохицуулсан байгааг онцлох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, ТТХтХ-д зайлшгүй хохирол учирсан бол мэдэгдэх тухай заасан бол ШШГтХ хэрэглэсэн тохиолдол бүрийг мэдэгдэх тухай заасан онцлогтой байна. Иймд галт зэвсэг хэрэглэх зохицуулалт бүрийг харилцан адилгүй байдлаар өөр өөр хуулиар тогтоож, хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор

болон тухайлсан байгууллагын даргын баталсан журмаар харилцан адилгүй зохицуулж байна. Энэ нь хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар хууль сахиулах үйл ажиллагааг харилцан адилгүй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Цаашилбал, тус Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын илтгэх мэдээллэх журам нь Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын баталсан 2017 оны 9-р сарны 06-ны өдөр А225 тоот дугаараар батлагдан гарсан байна. Тус журамд галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд хэнд хэрхэн, ямар дэс дарааллаар илтгэх, мэдэгдэх тухай нарийн үйл явцыг дэлгэрэнгүй зохицуулсан байна. Тухайлбал, тус журмын 2.2-т зааснаар “Хүний амь нас, эрүүл мэнд хохирсон тохиолдолд хорих анги, байгууллагын дарга болон харьяа прокурорын газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын жижүүрийн албанд харилцаа холбооны хэрэгслээр буюу эсхүл тухайн алба хаагч өөрийн биеэр даруй мэдэгдэж хэргийн газрыг хамгаалалтад авна” хэмээн нарийвчлан зохицуулсан байна. Энэ нь алба хаагчдад ойлгомжгүй байдал, хуулийн хэрэгжилтэд хүндрэл учрахаас урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой байна.

Гэвч ТТХТХ-д галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх мэдэгдэх журам байх ёстой эсэх, хэн хэрхэн батлах тухай зохицуулалт агуулаагүй байх бөгөөд зэвсэг хэрэглэсний улмаас хохирол учирсан болон учраагүй тохиолдолд хэрхэн, яаж мэдэгдэх тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй байгааг шүүмжлэх нь зүйтэй. Үүний улмаас ТТХГ-ын албан хаагчид одоогийн байдлаар нэг ч удаа галт зэвсэг нээсэн тохиолдол практикт бүртгэгдээгүй байна. Шалтгаан нөхцлийг тодруулахад “галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд яах нь маш тодорхойгүй байдаг учраас галт зэвсэг хэрэглэхээс татгалздаг” тухай алба хаагчид хариулсан байна. Иймд галт зэвсэг ямар тохиолдолд хэрхэн хэрэглэх тухай, хэрэглэсний дараагаар хэнд ямар журмаар хандах тухай нарийвчилсан зохицуулалт дутагдаж байна.

Гадаад орны туршлагаас үзвэл галт зэвсэг хэрэглэхээс өмнө болон дараа нь мэдэгдэх бөгөөд мөн дээд албан тушаалтнаас галт зэвсэг биедээ авч явах зөвшөөрөл авах тухай зохицуулалт мөн агуулж байна. Тухайлбал, БНСУ-ын Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хуулийн 19-р зүйлд Зэвсэг биедээ авч явах, хэрэглэх тухай дараах байдлаар заасан байна:

1. Тусгай хамгаалалтын газрын дарга нь албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд албан хаагчид зэвсэг биедээ авч явах зөвшөөрөл олгоно хэмээн заасан байна.

Харин АНУ-ын холбогдох хуульд дотоод болон гадаадын нутаг дэвсгэрт зэвсэг авч явах бүрэн эрхийг дараах байдлаар хуульчлан зохицуулсан байна⁴⁴.

А. АНУ-ын 22-р хуулийн 2709-р зүйлд заасан АНУ-ын тусгай албан хаагчид албан үүрэг гүйцэтгэхдээ дараах дүрэм журмын дагуу галт зэвсэг авч явах, ашиглах эрхтэй.⁴⁵

Галт зэвсэг авч явах зөвшөөрөл

Б. Галт зэвсэг авч явах зөвшөөрөлгүйгээс бусад тохиолдолд АНУ-ын нутаг дэвсгэрт алба хаагч нь энэхүү журмын дагуу зөвшөөрөгдсөн галт зэвсэг авч явах эрхтэй. Алба хаагч өөрийгөө галт зэвсэг авч явахад тохиромжгүй гэж итгэх үндэслэлтэй тохиолдолд дээд шатны алба хаагчид заавал мэдэгдэнэ.

В. АНУ-ын хууль тогтоомжийн дагуу галт зэвсэг авч явах эрхийг хуулиар хязгаарлаагүй тохиолдолд АНУ-ын гадна нутаг дэвсгэрт алба хаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу Газрын даргаас бичгээр зөвшөөрөл авснаар галт зэвсгээ гадаадад авч явах боломжтой.

Г. Алба хаагч бүр эдгээр журамд заасан өөрийн эрх үүргийн талаар бүрэн ойлголттой байх үүрэгтэй.

Зөвшөөрөгдсөн галт зэвсэг

А. Тусгай алба хаагчид төрийн захиргааны байгууллагаас батлагдан гарсан гар буу, бүрээс, туслах зэвсэг (шумбагч буу, ангийн буу, тусгай зориулалтын галт зэвсэг) болон сум зэргийг авч явахыг зөвшөөрнө.

Ажлаас гадуурх болон хоёрдогч зэвсэг

А. АНУ-д үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж байх хугацаандаа албаны зэвсгээ авч явах эрхтэй байж болно. Энэ заалт нь холбооны, муж, орон нутгийн хууль тогтоомжийн дагуу хувийн иргэн эсвэл мэргэшсэн хууль

⁴⁴ Authority to Carry Firearms

Section 2709 of Title 22, United States Code, authorizes special agents of the U.S. Department of State to carry and use firearms in the performance of their duties, consistent with these regulations.

⁴⁵ Authority to Carry Firearms

Section 2709 of Title 22, United States Code, authorizes special agents of the U.S. Department of State to carry and use firearms in the performance of their duties, consistent with these regulations.

сахиулагчийн хувьд бусад галт зэвсгийг үүргээс гадуур тээвэрлэхэд саад болохгүй.

Б. АНУ-д албан үүргээ гүйцэтгэж байхдаа тусгай алба хаагч нь албаны зэвсгээсээ гадна нэг хоёрдогч гар буу авч явах эрхтэй байж болно. Хоёрдогч гар буу нь Төрийн захиргааны байгууллагаас батлагдан гарсан гар бууны жагсаалтад орсон байх ёстой.

В. Тусгай алба хаагч хоёрдогч гар бууг зөөвөрлөхийг зөвхөн батлан гаргасан стандарт, болон шаардлагатай зөвшөөрлийг хангасан тохиолдолд л зөвшөөрнө.

Г. Зэвсгийг бүрэн тодорхойлсон хавсаргасан бичиг баримт, тээвэрлэлтийг анх зөвшөөрсөн огноо байхгүй бол хоёрдогч гар буу хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Мэргэшсэн байдал

- Тусгай зөвшөөрлөөр олгосон галт зэвсэг авч явах эрх авахын тулд алба хаагч галт зэвсгээрээ төрийн захиргааны байгууллагын мэргэшлийн курст заасан оноог хангасан буюу түүнээс дээш оноо авч тэнцсэн тохиолдолд олгоно. Тусгай алба хаагч нь сүүлийн 12 сарын хугацаанд шаардлагатай галт зэвсгийн сургалт, танилцах процедурыг амжилттай биелүүлээгүй тохиолдолд галт зэвсгийг авч явахыг зөвшөөрөхгүй хэмээн тус тус хуульчлан зохицуулсан байна.

Иймд гадаад улсын хууль тогтоомжоос үзвэл зөвхөн галт зэвсэг хэрэглэсэн тухай мэдээлэл өгөхөөс гадна галт зэвсэг биедээ авч явах зөвшөөрөл авах, сургалтад хамрагдах болон галт зэвсэг нээх болон нээсний дараа мэдэгдэх зэрэг үйл явцыг нарийвчлан зохицуулсан байх тул туршлага судлан дотоодын хуль тогтоомждоо нутагшуулах нь зүйтэй.

Тус хуулийн 22-р зүйлийн 1 дэх хэсэгт Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч галт зэвсэг хэрэглэх тохиолдлыг хуульчлан зохицуулсан байна. Үүнд;

- 1/хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйл, үүргээ гүйцэтгэж байгаа хамгаалалтын алба хаагчид галт зэвсэг хэрэглэн халдсан буюу халдахыг завдсан;
- 2/хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар халдсан буюу халдахаар завдсан этгээдийн үйлдлийг өөр аргаар таслан зогсоох боломжгүй;

- 3/хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийг барьцаанд авахаар завдсан үйлдлийг таслан зогсоох, барьцаанаас чөлөөлөх.

Зэрэг дээрхи тохиолдолд алба хаагч галт зэвсэг нээх эрхтэй тухай ТТХТХ-д хуульчлан зохицуулсан байна. Гэвч эдгээр нөхцөлд алба хаагч галт зэвсэг нээсэн тохиолдол нэг ч удаа бүртгэгдээгүй байгааг онцолж, тус хуулийн зүйл заалт нь бодитоор хэрэгжиж байгаагүй, хэрэгждэггүй байна. Олон Улсын хүний эрхийн стандартад зааснаар хууль сахиулагч нь хүчийг гарцаагүй нөхцөлд эцсийн арга болгон тохирсон хэм хэмжээнд бүрэн хяналтын дор хэрэглэх ийнхүү хэрэглэхдээ хамгаалах аргад суурилах зарчмыг заасан байдаг⁴⁶. Харин манай улсын хувьд хүч, албадлага хэрэглэх эрх хэмжээг хэт ерөнхий байдлаар хуульчилсан төдийгүй үндэслэлийг харилцан адилгүй байдлаар өөр өөр хуулиар тогтоож, хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор болон тухайлсан байгууллагын даргын баталсан журмаар харилцан адилгүй зохицуулж байна. Энэ нь хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар хууль сахиулах үйл ажиллагааг харилцан адилгүй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Иймд галт зэвсэг хэрэглэх онцгой тохиолдлуудыг гадаадын зарим улс орнууд хэрхэн хуульчлан зохицуулсан байгааг харьцуулан судлан үзвээс БНСУ-ын Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хуулийн 19-р зүйлд Зэвсэг биедээ авч явах, хэрэглэх тухай дараах байдлаар заасан байна:

- А. Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай гэж үзвэл албан хаагч харьяалах даргын зөвшөөрлөөр зэвсэг хэрэглэж болно.
- Б. Харин хуулиар заасан бусад тохиолдолд хүнд гэмтэл учруулж үл болно.
 1. Эрүүгийн хуулийн 21-р зүйл, 22-р зүйлд заасан нөхцөл байдал үүссэн бол
 2. Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хуулийн 4.1-д заасан хамгаалуулагчийн хамгаалалтыг хийх явцад илрүүлсэн цаазын ял, бүх насаар хорих ял болон 3-аас дээш жилээр хорих ялтай гэмт хэрэг үйлдсэн эсвэл сэжигтэн этгээдийг баривчлахаас өөр аргагүй үед болох

⁴⁶ Хууль сахиулагчийн зан үйлийн дүрэм - Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны 34/169А тоот тогтоол. Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим. НҮБ-ын 8 дугаар Их хурал. 1990-8-27.

эсхүл тусгай алба хаагчийн хамгаалалтын ажилд саад учруулах, зугтахаар алба хаагчид халдахад түүнийг таслан зогсоох, баривчлахад зэвсэг хэрэглэхээс өөр аргагүй болсон тохиолдолд

3. Хамгаалалтын үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор шөнийн цагаар эсвэл бүлэглэн хүйтэн зэвсэг мэтийн аюултай зүйлс биедээ авч явж, алба хаагчид халдах тохиолдолд үүнийг таслан зогсоох, баривчлах зорилгоор зэвсэг хэрэглэхээс өөр аргагүй болсон тохиолдолд

хэмээн тус тус хуульчлан заасан байна. Иймд алба хаагч хамгаалалтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад саад учруулж, мөн гэмт хэрэг хийсэн гэх үндэслэлтэй, шалтгаантай буюу зайлшгүй тохиолдолд зэвсэг хэрэглэж болно хэмээн БНСУ-ын хуульд тусгайлан заасан байна.

Харин АНУ-ын жишгээс үзэхэд алба хаагчид галт зэвсэг авч явах бүрэн эрхийг *Үхэлд хүргэхүйц хүч хэрэглэх буюу галт зэвсэг хэрэглэх тухай* журмаар дараах байдлаар хуульчлан зохицуулсан байна.⁴⁷

- А. Дипломат Аюулгүй Байдлын Албаны (A special agent of the Diplomatic Security Service (DSS)) алба хаагч зөвхөн шаардлагатай тохиолдолд, өөрөөр хэлбэл албан хаагчийн бие махбодид ноцтой гэмтэл учруулах, үхэлд хүргэх аюул заналхийлж байна гэсэн итгэл төрсөн, үндэслэлтэй үед л үхлийн аюултай хүч хэрэглэж болно.
- Б. Зөвхөн оргон зугтаж буй сэжигтнийг зугтахаас сэргийлэхийн тулд үхэлд хүргэхүйц хүч хэрэглэж болохгүй.
- В. Зөвхөн хөдөлж буй тээврийн хэрэгсэл, хөлөг онгоц болон бусад тээвэрлэлтийг зогсоох зорилгоор галт зэвсгээр галлаж болохгүй.
- Г. Тухайн албан тушаалтны амь насанд халтай нөхцөл үүсээгүй тохиолдолд үхэлд хүргэхүйц хүч хэрэглэх тухай урьдчилж амаар анхааруулна.
- Д. Хамгаалалтын үүргийг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд анхааруулах буудлага хийхийг хориглоно.

⁴⁷12 fam 090, use of force policies and reporting (ct:ds-348; 02-22-2021) (office of origin: ds/do) 12 fam 091 less-than-lethal force: definition and guidelines for use <https://fam.state.gov/fam/12fam/12fam0090.html>

Е. Энэ журамд заасан үхлийн аюултай хүч хэрэглэхийг зөвшөөрөөгүй тохиолдолд эсэргүүцэл үзүүлж буй субъектуудтай харьцах өөр арга, тактикийн сургалтад алба хаагч сууна.

Дээрхи журмаас дүгнэвэл АНУ-ын үхэлд хүргэхүйц хүч хэрэглэх болон галт зэвсгийн тухай журам нь галт зэвсгийг ямар тохиолдолд хэрхэн хэрэглэх, мөн галт зэвсэг хэрэглэх эрхийг олж авахын тулд тусгай сургалтад хамруулахаар хуульчлан зохицуулсан байхаас гадна алба хаагчийн ямар төрлийн зэвсгийг зөвхөн хэрэглэх ёстой тухай нарийвчлан заасан байна. Мөн галт зэвсэг нээсний дараа болон нээхээс өмнө хэнд хэрхэн хандаж зөвшөөрөл авах тухай хуульчлан зохицуулсан онцлогтой байна. Мөн алба хаагч зөвхөн дотооддоо төдийгүй гадаадад албан үүргээ гүйцэтгэх тохиолдолд тусгай зөвшөөрлөөр зэвсэг авч явах эрхийг хуульчлан зохицуулсан байна. Мөн хөдлөн явж буй тээврийн хэрэгсэлрүү гал нээхийг хориглох зэрэг ямар тохиолдлуудад галт зэвсэг хэрэглэхийг ноцтой хориглох тухай тусгайлан заасан онцлогтой байна.

Мөн БНСУ болон АНУ-ын галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг харахаас гадна галт зэвсэг хэрэглэх тухай олон улсын гэрээ конвенц, олон улсын норм стандарт хэрхэн хэрэгжиж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх нь зүйтэй. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнтэй харьцах тухай НҮБ-ын 8-р конгрессоор 1990 оны 9-р сарын 7-ны өдөр “Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим” гэсэн НҮБ-ын тогтоол батлагдсан байна. Тус тогтоолд Монгол улс нэгдэн ороогүй ч олон улсын хэмжээнд галт зэвсэг хэрэглэх эрх зүйн орчин, стандартыг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага тулгарч байна.

“Хууль сахиулах байгууллагын албан тушаалтан хүний амь нас хохирох, хүнд гэмтэл учруулах аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, амь насанд халтай онц хүнд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлахаас бусад тохиолдолд хүний эсрэг галт зэвсэг хэрэглэхийг тусгайлан хориглосон байна. Ямар ч тохиолдолд амь насыг хамгаалахын тулд галт зэвсгийг ашиглахаас өөр аргагүй тохиолдолд л хэрэглэж

болно”⁴⁸ хэмээн үндсэн зарчим НҮБ-аас батлан гаргасан байх бөгөөд тус конвенцод галт зэвсэг хэрэглэх тухай албан хаагчийн мэргэшсэн байдлын стандарт, сургалт, зөвлөгөөний тухай нарийвчлан зохицуулсан байна. Мөн албан үүргээ биелүүлэх явцад галт зэвсэг хэрэглэсэн тухай тайлан мэдээг илтгэх хянах журмыг тусгасан байна.

Иймд БНСУ болон АНУ нь дээрхи олон улсын зарчмыг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн, бүрэн тусгаж чадсан байх бөгөөд дэлхий нийтээрээ олон улсын галт зэвсэг хэрэглэх тохиолдол, стандартыг өөрсдийн хууль тогтоомжид нутагшуулж буй хандлага ажиглагдаж байна. Тиймч учраас Монгол улс нь өөрийн холбогдох хууль тогтоомждоо нийцүүлэх шаардлага тулгарч байгаа төдийгүй тэр дундаа ТТХТХ-д олон улсын галт зэвсэг хэрэглэх, мэдээллэх стандартыг нийцүүлэх шаардлага практикт тулгамдаж байна. Өөрөөр хэлбэл, алба хаагчийн галт зэвсэг хэрэглэх болон хориглох тохиолдол нөхцөлийг нарийвчлан заах, мэдээллэх илтгэх журам, болон ямар төрлийн галт зэвсгийг хэрхэн хэрэглэх тухай нарийвчлан батлан гаргах шаардлагатай байна. Улмаар олон улсын стандарт дүрмийг нарийвчлан судлан өөрийн эрх зүйн орчинд нутагшуулах нь албан хаагчид, хамгаалуулагч болон бусдын аюулгүй байдлыг хамгаалахад практикт ойлгомжгүй байдал үүсэхээс сэргийлэх өндөр ач холбогдолтой юм.

⁴⁸ Хууль сахиулах байгууллагын албан тушаалтны хүч, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим, 1990 оны 8-р сарын 27-ноос 9-р сарын 7-ны хооронд Гавана, Куба, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэнтэй харьцах тухай НҮБ-ын 8-р конгресс <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-use-force-and-firearms-law-enforcement>

Дүгнэлт, Зөвлөмж

ТТХтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6-р хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу “Зорилгод хүрсэн түвшин” болон “Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

ТТХтХ-ын агуулгаас дүн шинжилгээ хийвэл төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаа нь улс орны тусгаар тогтнол, гадаад болон дотоодын аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашигт нийцүүлэн, хуульд заасны дагуу өндөр, дээд албан тушаалтны амь бие, эрүүл мэндийг хамгаалах үзэл баримтлалтай байна. Гэвч тус хуулийн хэрэгжилтийн явцад уг үзэл баримтлал ялимгүй хазайж, гадаад болон дотоодын хамааралгүй албан тушаалтнуудыг төрийн тусгай хамгаалалтад авч буй тохиолдлууд олонтаа гарч байна. Цаашилбал, Засгийн газрын 65 дугаар тогтоолоор “Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай зүйлийн жагсаалт”-ыг Засгийн газар хуульд заасан бүрэн эрхийн дагуу баталсан хэдий ч хууль ёсны шалгуур үзүүлэлтгүйгээр аливаа объектыг хамгаалалтад авахаар шийдвэрлэж буй байдал ажиглагдаж байна. Иймд тус хуулийн үзэл баримтлалд тулгуурлан төрийн тусгай хамгаалалтад хамаарах субъект болон объектын хамрах хүрээг нарийвчлан тогтоож, хууль ёсны шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох нь төрийн тусгай хамгаалалтын газраас хүн хүч дутагдах, улсын төсөвт дарамт учруулах, бүрэн гүйцэт байх зарчим алдагдах зэрэг асуудлаас урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т заасан “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол” хуулийн шинэчилсэн найруулга хийнэ гэж заасан байдаг. Үүнд үндэслэн ТТХтХ-ийн 18 зүйл заалтад дүн шинжилгээ хийхэд ТТХтХ-ийг шинэчилсэн найруулга хийх шаардлагатай байна. Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү үр нөлөөтэй болгох талаар дараах санал, зөвлөмжийг боловсрууллаа.

ТТХтХ-ын 3-р зүйлд “төрийн тусгай хамгаалалт”-ыг тодорхойлохдоо “аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалалтад авахаар тогтоосон төрийн байгууллага, тэдгээрийн зарим үйл ажиллагаа, албан тушаалтан, иргэний амь

бие, ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийг хамгаалахад чиглэсэн мэргэжлийн болон бусад байгууллага, албан тушаалтны харилцан уялдаатай цогцолбор үйл ажиллагаа” гэж заасан байна. Үүнээс үзвэл, “албан тушаалтан, иргэний амь бие, ордон, өргөө” зэрэгт юуг ойлгож байгаа нь тодорхойгүй байх ба хуулийн нэр томъёоны тодорхойлолт байхгүй улмаас тус хуулийн хэрэгжилтэд хүндрэл учруулж байна.

Жишээлбэл, “албан тушаалтан” гэсэн нэр томъёог “төрийн өндөр, дээд алба хашиж буй хүн”, “иргэн” гэснийг “төрийн өндөр, дээд алба хашиж байсан хүн” харин “ордон”, “өргөө” гэсэн нэр томъёоны ялгаа нь юу болох, юуг хамруулж ойлгох зэргийг нарийвчлан заасан нэр томъёоны тодорхойлолтыг хуульд тусгах шаардлагатай байна.

ТТХтХ-ийн 2 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан. Монгол Улс нь 1974 онд “Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц”-д нэгдэн орсон. Иймд Монгол Улсын Үндсэн Хуульд “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасныг үндэслэн ТТХтХ-д “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” хэмээх агуулгыг тусгах.

ТТХтХ-ийн 6 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн, өөрийн хамгаалалттай ирсэн гадны өндөр, дээд хэмжээний зочин” -ыг төрийн тусгай хамгаалалтад авах тухай хуульчлан зохицуулсан байна. Тус заалтын хүрээнд тодорхойлон заасан “албан тушаалтан” болон “өөрийн хамгаалалттай ирсэн өндөр, дээд хэмжээний зочин”-ыг ямар шалгуураар сонгож хамгаалалтад авч байгааг тодорхой болгоогүйгээс хуулийн хэрэгжилтэд хүндрэл учруулж байна. Тухайлбал, ТТХтХ-д “төрийн өндөр дээд алба хашиж байсан хүн”-ийг “Иргэн” гэдэг нэр томъёогоор илэрхийлж байгаа нь хууль хэрэглээний явцад төөрөгдөл үүсгэж болзошгүй байна. Тиймээс нэгдүгээрт, төрийн өндөр албан тушаалтан, иргэн гэж хэнийг хэлэх, ямар

шалгуураар хамгаалалтад авахыг нарийвчлан тусгаж, ойлгомжтой байдлаар томъёолох нь зүйтэй. Тухайлбал, хуулиар тусгай хамгаалалтад байхаар заасан албан тушаалтан, иргэнийг Монгол Улс ТТХ-д авна гэх зэргээр шалгуур тогтоох шаардлагатай.

Хоёрдугаарт, “өөрийн хамгаалалттай ирсэн гадны зочид, төлөөлөгч” нар гэсэн нэр томъёог хэрэглэснээр “өөрийн хамгаалалттай” ирсэн бол Монгол Улсын төрийн тусгай хамгаалалтад орох эрх зүйн орчин бүрэлдэж буй тул тус нэр томъёог өөрчлөх нь зүйтэй. Тухайлбал, “Монгол Улсад хуулиар ТТХ-д авахаар заасан төрийн өндөр, дээд албан тушаалтантай дүйцэхүйц алба хашдаг гадаад орны хүн”, “Олон улсын хамгаалалтад байдаг хүн”-гэх зэргээр олон улс болон бусад дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэн уялдаа холбоог хангах, ойлгомжтой байдлаар хязгаарлан хуульчлах, Монгол Улсын Үндэсний язгуур эрх ашгийг хамгаалах нь төрийн тусгай хамгаалалтын аюулгүй, тогтвортой, иж бүрэн байх боломжийг бүрдүүлэх, хамгаалалтын хүрээ хязгаарыг тодорхой болгохоос гадна хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах, хүн хүчний зохицуулалт, төсвийн зардлыг зохистой хэрэглэх боломж бүрдэх юм.

ТТХтХ-ийн 5-р зүйлийн 6 дахь хэсэгт “төрийн тусгай хамгаалалтын бүс” гэсэн нэр томъёог тодорхойлсон байх ба тус тодорхойлолтод ямар шалгуураар төрийн тусгай хамгаалалтын бүс гэж үзэх, хил хязгаарыг хэрхэн тогтоож байгаа эсэх нь тодорхойгүйгээс шалтгаалан аливаа барилга, бүс, арга хэмжээ, субъектыг төрийн тусгай хамгаалалтад авах асуудлыг хууль ёсны шалгуур үзүүлэлтгүйгээр шийдвэрлэдэг тохиолдол ажиглагдаж байна. Иймд, төрийн тусгай хамгаалалтын бүсийг тогтоохдоо тогтсон шалгуур үзүүлэлтийг баримтлах нь зохистой. Тухайлбал, иргэд, хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй, хохирол учруулахгүй, тэдгээрийн эрхийг хамгаалах үүднээс хамгаалалтын бүсийг байж болох хамгийн бага хэмжээгээр тогтоох ерөнхий шалгуур, зарчмыг хуульд тусгах шаардлагатай.

ТТХтХ-ийн 10-р зүйлийн 2 дахь хэсэгт “ТТХГ-ын бүтэц, зохион байгуулалт нь хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын болон дүн шинжилгээний нэгжээс бүрдэнэ” гэж тусгасан бөгөөд тус заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийхэд уг заалт нь одоо үйл ажиллагаа явуулж буй зохион байгуулалтын

бүтцэд нийцэхгүй байна. Тухайлбал, ТТХГ-ын бүтцэд “Холбооны нэгж” шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч ТТХТХ-д тусгагдаагүй тул уг зүйл заалтыг шинэчлэн найруулж, тус хуульд холбооны нэгжийг нэмж тусгах шаардлага тулгарч байна.

ТТХТХ-ийн 11 дүгээр зүйлд төрийн тусгай хамгаалалтын газрын эрх, үүргийг заасан байдаг. Хуульд заасан эрхийн агуулгыг нарийвчлан үзвэл тус байгууллагын эрх, үүрэг нь утгын хувьд давхацсан зүйл заалт байгааг анхаарч, ТТХГ-ын эрх үүргийг ангилж, шинэчлэн найруулах шаардлагатай байна.

ТТХТХ-ийн 11 дүгээр 1 дэх хэсгийн “төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын төв, орон нутгийн байгууллагаас туслалцаа авах, харилцан ажиллах” хэрэгжилтийн хүрээнд олон арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тэдгээр нь хамтын ажиллагааны уялдаа холбоотой, алдаа дутагдалгүй хэрэгжсэн онцлогтой байсан тул тус заалтын хэрэгжилтийн түвшин харьцангуй сайн гэж үнэлж байна.

ТТХТХ-ийн 12-р зүйлд ТТХГ-ын даргын бүрэн эрхийг хэт хязгаарлагдмал байдлаар хуульчлан зохицуулсан байна. ТТХГ-тай холбогдох журмуудыг дийлэнхи тохиолдолд Засгийн газар баталж байхаар хуульд зохицуулсан байгаагаас улбаалан аливаа дүрэм, журам батлахад хугацаа их шаардах, практиктай нийцэхгүй байх зэрэг сөрөг үр дагавар үүсч болзошгүй байна. Иймд газрын даргын бүрэн эрхийг нэмж, боловсронгуй болгож, шинэчлэн найруулах шаардлага тулгарч байна. Ингэснээр ТТХГ-ын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжрах, түргэн шуурхай явагдах зэрэг эерэг үр дагавартай.

ТТХТХ-ийн 13-р зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэнийг төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэнэ” гэж тусгасан байдаг. ТТХГ нь хамгаалалтын нэгжээс гадна үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын, дүн шинжилгээний болон холбооны нэгжтэй бөгөөд нэгж болгон тус тусын чиг

үүргийг хэрэгжүүлдэг. Гэвч ТТХтХ-д төрийн тусгай хамгаалалтын алба хаагч гэдэгт зөвхөн хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй иргэнийг тодорхойлсон нь агуулгын хувьд алдаатай байна. Иймд, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тодорхойлолтод ТТХГ-ын нийт алба хаагчдыг хамруулан тусгах нь зүйтэй. Тухайлбал, “хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа иргэн” гэснийг “төрийн тусгай хамгаалалтын газарт үүрэг гүйцэтгэж байгаа иргэн” гэх зэргээр агуулгыг шинэчлэн найруулах шаардлагатай.

ТТХтХ-ийн 10-р зүйлийн 6 дахь хэсэг мөн 13-р зүйлийн 3 дахь хэсэгт төрийн тусгай хамгаалалтын алба хаагч цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ гэж заасан. Үүнээс үзэхэд, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 136 дугаар зарлигын дагуу батлагдсан "Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам", Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуультай нийцэж буй байдлыг судлан үзэхэд ТТХтХ-ийн дээрхи 2 зүйл заалт нь бусад холбогдох хууль тогтоомж, журамтай нийцэж байх бөгөөд ТТХГ-ын алба хаагчид нь цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэх хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэлээ.

ТТХтХ-ийн 10-р зүйлийн 3 дахь хэсэгт Төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдэг нь тус байгууллагыг илэрхийлэх гол үнэт зүйл байдаг бөгөөд тэдгээрийг бусад хүн, хуулийн этгээд, өөр байгууллагууд ижил төстэйгөөр ашиглах нь хамгаалалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулж иргэд, хамгаалуулагчийг төөрөгдөлд оруулах эрсдэлтэй. Иймд иргэн, хуулийн этгээд төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварын туг, бэлгэ тэмдэг хэрэглэхийг хориглох заалтыг хуульд тусгах шаардлагатай. Ингэснээр цаашид учирч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх боломж бүрэлдэнэ.

ТТХтХ-ийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт “Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна” гэж заасан боловч төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх үед учирсан хохирлыг хэрхэх тухай тодорхой тусгаж өгөөгүйгээс алба хаагчийн эрх ашиг, албан үүргээ бүелүүлэх баталгаа хангагдахгүйд хүрэх эрсдэлтэй байгааг

дурдах нь зүйтэй. Тиймээс, ТТХтХ-д алба хаагчид учирсан хохирлыг төр хэрхэн хариуцах талаар тодорхой стандарт, зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуульд заасанчлан “алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно”, “алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон бол эмнэлгийн байгууллагаар үнэ төлбөргүй эмчлүүлнэ” гэх зэргээр нарийн зохицуулалтыг хуульд тусгаснаар ТТХ-ын алба хаагчийг үүргээ биелүүлэх баталгаагаар хангах юм.

ТТХтХ-ийн 17-р зүйлийн 3 дахь хэсэгт “Шаардлагатай тохиолдолд төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн амралтын цагийг хязгаарлах буюу илүү цагаар ажиллуулж болохоор зохицуулсан байна. Уг заалтын хэрэгжилтийн тухайд “шаардлагатай тохиолдол” гэж юуг ойлгох нь ойлгомжгүйн улмаас төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдыг онцийн шаардлагагүй тохиолдолд илүү цагаар ажиллуулах эрсдэл үүсэх магадлалтай байна. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь алба хаагчийн үүрэг хүлээсэн субъект болохын сацуу Үндсэн хуулиар олгогдсон хүний үндсэн эрхийг эдлэх учиртай. Тиймээс алба хаагчийг илүү цагаар ажиллуулах тохиолдолд хүний эрхийг хамгаалсан хэм хэмжээ, хязгаарыг тогтоох, илүү цагаар ажиллуулсан тохиолдолд шаардлагатай урамшуулал, хангамж олгох зохицуулалтыг хуульд нарийвчлан тодорхойлон тусгах нь зүйтэй. Тухайлбал, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгох зэргээр алба хаагчид илүү цагаар ажиллах үед нь дэмжлэг, хангамж үзүүлэх нь зүйтэй.

ТТХтХ-ийн 21-р зүйлд төрийн тусгай хамгаалалтын алба хаагч төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх талаар заасан. Төрийн тусгай хамгаалалтад зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврын 1.4.10-т “зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх”-ийг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч уг журамд алба хаагч зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэсний үр дүнд иргэний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд ямар арга хэмжээ авах талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Иймд зэвсэггүйгээр тулалдах мэх

хэрэглэснээс үүдэн гарсан үр дагавар, хохирлыг хэрхэх талаарх тодорхой зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай байна.

Тухайлбал, хүч хэрэглэснээс үүдэн бэртэл гэмтэл авсан, шархадсан, мөн эмнэлгийн тусламж авах шаардлагатай аливаа субъектэд боломжтой бол анхан шатны тусламж үзүүлэх, эмнэлгийн тусламж дуудах үүргийг хүлээлгэхээс гадна хүч хэрэглэсэн тухай бүртээ холбогдох удирдлагадаа заавал мэдэгдэх зэргээр журамд нарийвчлан зохицуулалт тусгаж өгснөөр ТТХГ-ын алба хаагчдад, бусад хууль хэрэглэгчдэд, эрсдэлт бүхий иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэхээс урьдчилан сэргийлж, хууль хэрэгжилтийн түвшинд эерэг үр дагавар үүсэх боломжтой.

ТТХГ-ийн 22-р зүйлийн 5 дахь хэсгийн агуулгад дүн шинжилгээ хийвээс зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэснээс болж зайлшгүй хохирол учирсан бол мэдэгдэх тухай заасан бол ШШГТХ-д зэвсэг хэрэглэсэн тохиолдол бүрийг мэдэгдэх тухай заасан онцлогтой байна. Иймд галт зэвсэг хэрэглэх зохицуулалт бүрийг харилцан адилгүй байдлаар өөр өөр хуулиар тогтоож, хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурор болон тухайлсан байгууллагын даргын баталсан журмаар харилцан адилгүй зохицуулж байна.

Цаашилбал, тус Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын илтгэх мэдээллэх журам нь Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын баталсан 2017 оны 9-р сарны 06-ны өдөр А225 тоот дугаараар батлагдаж, тус журамд галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд хэнд хэрхэн, ямар дэс дарааллаар илтгэх, мэдэгдэх тухай нарийн үйл явцыг дэлгэрэнгүй зохицуулсан байна. Гэвч ТТХГ-д галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх мэдэгдэх журам батлагдаагүй байх бөгөөд, хэн хэрхэн батлах тухай зохицуулалт хуульд тусгагдаагүй байгааг шүүмжлэх нь зүйтэй. Үүний улмаас ТТХГ-ын албан хаагчид одоогийн байдлаар галт зэвсэг нээсэн тохиолдол практикт бүртгэгдээгүй байна. Иймд галт зэвсэг ямар тохиолдолд хэрхэн хэрэглэх тухай, хэрэглэсний дараагаар хэнд ямар журмаар хандах тухай нарийвчилан зохицуулах шаардлагатай. Гадаад улсын хууль тогтоомжоос үзвэл зөвхөн галт зэвсэг хэрэглэсэн тухай мэдээлэл өгөхөөс гадна алба хаагчид галт зэвсэг биедээ авч явах зөвшөөрөл авах, сургалтад хамрагдах, галт зэвсэг нээх болон нээсний дараа мэдэгдэх зэрэг үйл явцыг нарийвчлан зохицуулсан байх тул туршлага судлан дотоодын хууль тогтоомждоо

нутагшуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, алба хаагчийн галт зэвсэг хэрэглэх болон хориглох тохиолдол, мэдээллэх илтгэх журам, болон ямар төрлийн галт зэвсгийг хэрхэн хэрэглэх тухай нарийвчлан батлан гаргах шаардлагатай. Ингэснээр, хууль хэрэглээний явцад ойлгомжгүй байдал үүсэхээс сэргийлэх өндөр ач холбогдолтой.

Ном зүй

Хууль тогтоомж

1. Монгол улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль. 1995 он.
3. Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он.
4. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль. 2004 он.
5. Төрийн албаны тухай хууль. 2017 он.
6. Хууль тогтоомжийн тухай хууль. 2015 он.
7. Цэргийн албаны тухай хууль. 2016 он.
8. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2016 он.
9. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. 1994 он.
10. Монгол улсын Засгийн газрын 65 дугаар тогтоол.
11. Засгийн газрын 2012 оны 65 дугаар тогтоолын хавсралт
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=8747>
12. Хууль тогтоомжийн тухай хууль. 2015 он.
13. Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журам. 2021 он.

Ном, бусад эх сурвалж

14. Төрийн тусгай хамгаалалтын тухай. УБ., 2018 он.
15. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар. 2010 он.
16. Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц. 2017 он.
17. Төрийн тусгай хамгаалалтад зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар. 2015 он.
18. Нийгмийн хэв журам ба хүний эрх, Цагдаагийн байгууллагын албан хаагчдын гарын авлага.
https://nhrcm.gov.mn/media/documents/1365649162_niigmiin_hev_juram_ba_hunii_erh.pdf
19. Төрийн тусгай хамгаалалтын газрын цахим хуудас.
<https://sspa.gov.mn/mn/page?id=1>
20. Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц.
21. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он.

22. Хууль сахиулагчийн зан үйлийн дүрэм - Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны 34/169А тоот тогтоол.
23. Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим. НҮБ-ын 8 дугаар Их хурал. 1990-8-27.

Гадаад эх сурвалж

24. БНСУ Ерөнхийлөгчийн хамгаалалтын тухай хууль. 2005 он.
25. БНСУ Аюулаас хамгаалах тухай нэгдсэн хууль. 1997 он.
26. Federal restricted buildings and grounds improvement act, 2011.
27. 18 U.S. Code §30563056 - Powers, authorities, and duties of United States Secret Service <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3056>
28. The Federal Restricted Buildings and Grounds Improvement Act of 2011 <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-9834/pdf/COMPS-9834.pdf>
29. АНУ-ын Нууц албаны цахим хуудас. [https://www.secretservice.gov/sites/default/files/reports/2020-09/USSS-Office-
Org-Chart-2020.pdf](https://www.secretservice.gov/sites/default/files/reports/2020-09/USSS-Office-Org-Chart-2020.pdf)
30. ОХУ-ын Холбооны хамгаалалтын алба (ХХА)-ны цахим хуудас. <http://www.fso.gov.ru/struktura/p8.html>



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨГ ЭРХЛЭХ ГАЗАР
Cabinet Secretariat of Government of Mongolia

НҮҮР БИДНИЙ ТУХАЙ Мэдээ мэдээлэл ИЛ ТОД БАЙДАЛ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ 11-11 ТӨВ НЭЭЛТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ ХЭХ ҮНДЭСНИЙ ХОРОО

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

МЭДЭЭНИЙ АНГИЛАЛ

ОРСОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

АЛСЫН ХАРАА-2050

ШИНЭ МЭДЭЭ

Үндэсний баазгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолыг баталлаа
2024-05-01

ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭД ИБУУНХУ-ЫН ТАДААХ ХЭРЭГ, ХАМТЫН НӨХӨРЛӨЛ, ХӨГЖИЛИЙН САЙД ДЭВИД КАМЕРОН БАРААЛХАВ
2024-04-26

"20 минутын хоёр" стандартын бий болгох эрх зүйн шинэчлэл хийнэ
2024-01-24

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Бүгд Найрамдах Киргиз Улсын Парламент Жогорку Кенеш-ийн дарга Н.Шамиев бараалхав
2024-04-24

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ: Боомтгүй боомийг тайлсан шиг эрчим хүчний реформыг эрчимжүүлнэ
2024-04-19

ФАЙЛЫН САН

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИСЭН

Орлого, зардал, хөрөнгийн үйлдвэрлэл

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 16 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсгээс боловсруулсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авч байна.

Саналаа dudjushuu@cabinet.gov.mn хаягаар болон бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хандан ирүүлнэ ҮҮ.

Холбоо барих утас: 263054

